



World Vision

The Asia Foundation



ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭЖ ОЛСОН ХӨРӨНГӨ, ОРЛОГООР ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЖ БУЙ ПРАКТИК

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2024 он

МЭДЭГДЭЛ

Энэхүү судалгааны тайланг Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн болно. Энд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын болон Азийн сангийн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

- ХХГХ – Хүн худалдаалах гэмт хэрэг
- НҮБ – Нэгдсэн Үндэстний байгууллага
- АНУ – Америкийн Нэгдсэн Улс
- УЕПГ – Улсын Ерөнхий Прокурорын Газар
- ЭХ – Эрүүгийн хууль
- ЭХХШТХ – Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
- ЗГТСТХ – Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- ХЗТ – Хууль зүйн туслалцаа
- ХЗДХЯ – Хууль зүй, дотоод хэргийн яам
- МАШ – Мөрдөж шалгах ажиллагаа

ӨМНӨХ ҮГ

УДИРТГАЛ.....	1-6
НЭГ.ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭЖ ӨЛСӨН ХӨРӨНГӨ, ОРЛОГООР ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЖ БУЙ ПРАКТИКТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН	7-32
Хохирогчид учирсан хохирлыг барагдуулах үүднээс гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, олсон орлогыг олж тогтоох, хураах, битүүмжлэх ажиллагааны явц, үр	7-14
Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй ажиллагааны шат бүрд хохирол барагдуулах ажиллагаа хэрхэн хийгдэж байгааг судлан тодорхойлж, дүгнэлт гаргах.....	14-18
Хохирол барагдуулсан, нөхөн олговор олгохоор шийдвэрлэсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг судлан, хэлбэрүүдийг тогтоох.....	18-23
Хохирогчид нөхөн олговор олгох ажлыг цаашид хэрхэн сайжруулах талаар санал гаргах	24-26
Дүгнэлт.	26-29
Санал, зөвлөмж	29-32
ХОЁР.ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИКТ ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН	33-44
Ерөнхий мэдээлэл	33-34
ХХГХ-ийн хохирогчид учирсан хохирлын тухай.....	34-36
Хүний биед учирсан өвчин, эмгэгийг нотолж буй практик.....	36
Хүний оюун санааны гэмтлийг тогтоож буй практик.....	36-37
ХХГХ-ийн хохирогчийн амьдралын чанарын тухай.....	37-43
ХХГХ үйлдэж олсон орлогын тухай	42-44
Дүгнэлт.	45
Санал, зөвлөмж	45-46

УДИРТГАЛ

Монгол Улс 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц”-ийн нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” протоколд нэгдэн орж соёрхон баталсан билээ.¹

Уг протоколын 6 дугаар зүйлийн 6-д “Оролцогч улс бүр дотоодын хууль зүйн тогтолцооны хүрээнд Хүн худалдаалах хэргийн хохирогчид учирсан хохиролдоо нөхөн төлбөр авах боломж олгож байх арга хэмжээг харгалзсан нөхцөлөөр хангана” гэж заасан.

Мөн “Хүн худалдаалах хэргийн хохирогчдыг хамгаалах болон туслах талаар “Хүн худалдаалах хэргийн хохирогчдыг бие бялдар, сэтгэл зүй болон нийгэмд эзлэх байр суурийг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зохих орон байраар хангах, хохирогчид ойлгогдох хэлээр, хууль ёсны эрхийн нь тайлбарлах, зөвлөгөө мэдээлэл өгөх, эмнэлгийн, сэтгэл зүйн болон материаллаг туслалцаа үзүүлэх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших суралцах боломжоор хангах асуудлыг хохирогчийн нас, хүйс, тусгай хэрэгцээ, орон байр, боловсрол, асран халамжлах” талаар тусгасан байдаг.

Протоколд нэгдэн орж соёрхон баталсны дагуу манай улс 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хуулийг батлан гаргасан.

Уг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Хохирогч нь эд хөрөнгө, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй” гэж, мөн зүйлийн 15.2 дахь хэсэгт “Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө”² гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газраас АНУ-ын Төрийн Департаменттай хамтран “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт гэрээ”-г байгуулсан ба уг гэрээний хүрээнд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоор гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлж буй практик судалгаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг анхааралдаа авч, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд учирсан гэмтэл, хохирлыг нөхөн сэргээхэд

¹ Монгол Улсын Их Хурлын 2008 оны 05-р сарын 16-ны өдрийн хуулиар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн протоколд Монгол Улс нэгдэн орсон.

² Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль 2012 он.

чиглэсэн цогц үйлчилгээ үзүүлж, улмаар энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарлаа хандуулж олон төсөл хэрэгжүүлж байгаа билээ.

Үүний нэг нь “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллага, “Азийн сан” олон улсын байгууллагууд хамтран хэрэгжүүлж байгаа “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоор гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлж буй практик судалгаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэх” төсөл бөгөөд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Улсын ерөнхий прокурорын газар, Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба зэрэг газрууд хариуцан ажиллаж байна.

Энэ удаад дээрх төслийн хүрээнд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч насанд хүрээгүй хүнд учирсан хохирлыг барагдуулах, нөхөн олговор олгох хууль эрх зүйн үндэслэл, тогтолцооны загварыг судлан тодорхойлж, дутагдалтай талыг сайжруулах шаардлагатай гэж үзэн **“Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийн хохирлыг нөхөн төлөхөд ашиглах”** зорилгоор практикийн бодлогын судалгааг хийлээ.

Судалгаанд “Хүн худалдаалах гэмт хэрэг”-ийн хохирогч, ялангуяа насанд хүрээгүй хохирогчид учирсан хохирлыг барагдуулахын тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ямар ажиллагааг хийж байгаа, хохирол төлбөрийг аль шатанд нь, хэрхэн барагдуулж байгаа, хохирогч, түүний эрх ашгийг хамгаалж байгаа талуудын хийж болох ажиллагаа, хохирогчид хохирол, нөхөн төлбөрөө барагдуулахад шаардлагатай мэдээллийг хэрхэн өгч байгаа зэрэг асуудлуудад анхаарлаа хандуулсан.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид учирсан хохирлыг барагдуулах, нөхөн олговор олгох ажиллагааны эрх зүйн орчин, бүтэц, тогтолцоо, хэвшмэл загварыг судлан тодорхойлж, түүнийг олон улсын сайн туршлагаар баяжуулан өөрийн улсад хэрэгжүүлж болохуйц зохистой байдлаар сайжруулах, ингэснээр хохирогчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, дахин ийм эрсдэлд орохоос сэргийлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулахыг зорьж дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

1. Хохирогчид учирсан хохирлыг барагдуулах үүднээс гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, олсон орлогыг олж тогтоох, хураах, битүүмжлэх ажиллагааны явц, үр дүнгийн талаар дүн шинжилгээ хийх;

2. Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй ажиллагааны шат бүрд хохирол барагдуулах ажиллагаа хэрхэн хийгдэж байгааг судлан тодорхойлж, дүгнэлт гаргах;
3. Хохирол барагдуулсан, нөхөн олговор олгохоор шийдвэрлэсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг судлан, хэлбэрүүдийг тогтоох;
4. Хохирогчид нөхөн олговор олгох ажлыг цаашид хэрхэн сайжруулах талаар санал гаргах зэрэг асуудлуудад анхаарал тавьж ажиллана.

Судалгааны ажлын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч Хүн худалдаалах гэмт хэргийг шалгах эрх бүхий 5 мөрдөгч болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 5 ажилтантай хийсэн түүвэр судалгааг ярилцлагын аргаар авсан.

Мөн баримт бичиг судлах аргаар ХХГХ-ийн хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой хууль, тогтоомж, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын хийсэн судалгаа, батлагдсан тоон мэдээлэл, гадаад орны туршлага зэрэг судалгааны мэдээллийг цуглуулан дүгнэлт хийж ажилласан.

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургаа дугаар зүйлийн 16.12 дахь хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөөн зөрчигдсөн гэж үзвэл уулэрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх”³ гэж, мөн зүйлийн 16.14 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”⁴ гэж тус тус тунхагласны дагуу зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, учирсан хохирлоо буруутай этгээдээс шаардан, гаргуулах эрхтэй байдаг.

Манай улс өнөөдрийн байдлаар олон улсын хүний эрхийн 50 орчим гэрээ, конвенцод нэгдэн орсон. Хүн худалдаалах асуудлыг шууд хөндсөн олон улсын гэрээ конвенцоос 1979 оны “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” НҮБ-ын конвенцод 1981 онд, НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенцод 2000 онд, мөн Конвенцын “Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оруулахаас сэргийлэх тухай”, “Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуунд татагдахаас хамгаалах тухай”

³ Монгол улсын Үндсэн хуулийн 2-р бүлгийн 16-р зүйлийн 12, 14 дэх заалт.

⁴ Монгол улсын Үндсэн хуулийн 2-р бүлгийн 19-р зүйлийн 1, 3 дах заалт.

Протоколуудад 2002 онд, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 онд баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”, түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”, “Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол”, “Галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протокол”-д 2008 онд тус тус нэгдэн орсон ба Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн хохирол, нөхөн төлбөрийг барагдуулахтай холбоотой асуудлуудад анхаарлаа хандуулж, хууль тогтоомждоо тусгасаар ирсэн.

Мөн Палермогийн протоколын 2 дугаар бүлэгт “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хувийн амьдралыг болон бие хүний хувьд тухайн хэргийн шүүн таслах ажиллагааг нууцлах замаар дотоодын хууль тогтоомжоор байж болох хэмжээнд хамгаална. Хохирогчдын бие бялдар, сэтгэл зүй, нийгэмд эзлэх байр суурийг нь нөхөн сэргээх, орон байраар хангах, ойлгогдох хэлээр эрхийн талаар нь мэдээлэл зөвлөгөө өгөх, эмнэлгийн болон сэтгэл зүйн материаллаг туслалцаа үзүүлэх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших, суралцах бололцоогоор хангах, нөхөн төлбөр авах боломж олгох хууль зүйн тогтолцоог бий болгоно” гэж заасан байдаг⁵ тул хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нар өөрт учирсан гэм хорын хохирол, сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэндийн хохирлоо гаргуулах, тэтгэвэр, тэтгэмж авах, хөрөнгө эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй билээ. Тодруулбал:

⁵ Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”, түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, 2000.

Хүснэгт 1.ХХГХ-ийн хохирогчид учирсан хохирлын төрөл



Хохирогч болон тэдний хууль ёсны төлөөлөгч нар хамгийн түгээмэл тохиолддог дээрх эрхүүдийг мэддэггүй учраас тэдэнд хохирол төлбөрөө гаргуулах эрхийн талаар мэдээлэл өгөх, шаардлагатай баримт бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх шаардлагатай байдаг.

Мөн хохирогчид эмнэлгийн үзлэг шинжилгээ хийлгэх, шинжээчийн дүгнэлт гаргуулах зэрэг ажиллагааг хийлгэх үед дараалал ихтэй байдаг нь мөрдөгч нарын ажилд хүндрэл учруулдаг байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг олж тогтоох нь нарийн төвөгтэй, олон талт ажиллагаа шаарддаг тул дараах аргуудыг ашиглан гэмт хэргийн орлого, хөрөнгийг олж тогтоох боломжтой. Тухайлбал:

Хүснэгт 2. Гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө орлогыг олж тогтоох ажил



Санхүүгийн мөрдөн шалгалтыг дараах байдлаар хийдэг.

- **Банкны гүйлгээний шинжилгээ**
 - Банкны данснуудыг хянах: Гэмт хэрэгтэн болон тэдний холбоотой хүмүүсийн банкны данснуудыг хянах. Энд дансны эзэмшигчийн нэр, гүйлгээний түүхийг шалгана.
 - Сэжигтэй гүйлгээг илрүүлэх: Банкны гүйлгээний хуулиас гадуур хийгдсэн гүйлгээ, их хэмжээний бэлэн мөнгөний хөдөлгөөн, банкны дансанд олон удаагийн, тодорхой цагуудад давтамжтай, бага хэмжээгээр шилжүүлсэн мөнгө зэргийг илрүүлэх.
- **Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл**
 - Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл: Гэмт хэрэгтэн болон тэдний холбоотой хүмүүсийн нэр дээр бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгүүдийг шалгах.
 - Автомашинны бүртгэл: Автомашинны бүртгэлүүдийг шалгах, их хэмжээний үнэтэй автомашин эзэмшиж байгаа эсэхийг тогтоох.
- **Санхүүгийн тайлан, бүртгэл**
 - Компанийн тайлан: Гэмт хэрэгтэнтэй холбоотой байж болох компаниудын санхүүгийн тайлан, бүртгэлийг хянах.
 - Татварын бүртгэл: Гэмт хэрэгтэн болон тэдний холбоотой хүмүүсийн татварын тайланг шалгах, орлогын эх үүсвэрийг тодорхойлох.

1. Нотлох баримт цуглуулах

- Хяналт, мөрдөх ажиллагаа
 - Гэрчийн мэдүүлэг: Гэрч, хохирогчоос мэдүүлэг авахдаа нотлох баримтыг тодруулах, тэдний өгсөн мэдээллийг шалгах,
 - Гүйцэтгэх ажиллагаа: Шаардлагатай тохиолдолд далд мөрдөх, гүйцэтгэх ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулах

2. Шүүхийн шийдвэрийн дагуу

- Хөрөнгийг хураах: Гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг хураах тухай шүүхийн шийдвэр гаргуулж, хэрэгжүүлэх
- Нотлох баримт бүрдүүлэх: Хөрөнгийн эх үүсвэр, гүйлгээний баримт, гэрчийн мэдүүлэг зэргийг нотлох баримт болгон бүрдүүлэх.

3. Олон улсын хамтын ажиллагаа

- **Мэдээлэл солилцоо**
 - *Олон улсын байгууллагууд*: Интерпол, Европол, тухайн улсын хүн худалдаалахтай тэмцэх тогтолцооны дагуу хууль сахиулах байгууллагууд зэрэг олон улсын хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах.
 - *Тусламжийн хүсэлт*: Бусад орнуудын хууль сахиулах байгууллагуудаас тусламж хүсэх, хамтран мөрдөн шалгах.

4. Тусгайлсан гэрээ, конвенц

- *Олон улсын конвенц*: Мөнгө угаахтай тэмцэх, гэмт хэргийн улмаас олсон хөрөнгийг буцаан авах олон улсын конвенц, гэрээ ашиглах
- *Харилцан туслалцаа*: Олон улсын харилцан туслалцааны гэрээ, хэлэлцээрийн дагуу мэдээлэл, нотлох баримт солилцох

5. Технологийн дэвшил

- **Мэдээллийн технологи**
 - *Мэдээллийн сангийн шинжилгээ*: Хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн сангуудыг ашиглан гэмт хэрэгтэнтэй холбоотой мэдээллийг хайх.
 - *Мэдээлэл олборлолт*: Гэмт хэрэгтний санхүүгийн болон бусад мэдээллийг олборлох, дүн шинжилгээ хийх.
- **Дижитал мөрдөн шалгалт**
 - *Цахим мөр*: Гэмт хэрэгтний цахим мэдээллийг (имэйл, нийгмийн сүлжээ, интернэт банкны гүйлгээ гэх мэт) мөрдөх
 - *Кибер аюулгүй байдал*: Кибер аюулгүй байдлын арга хэрэгслүүдийг ашиглан гэмт хэрэгтний цахим гэмт хэргийг илрүүлэх, мөрдөх.

6. Олон нийтийн дэмжлэг, мэдээлэл

- **Иргэдийн оролцоо**
 - *Мэдээллийн урамшуулал*: Иргэдэд гэмт хэрэгтний талаарх мэдээлэл өгвөл урамшуулал олгох.
 - *Нийгмийн ухамсар*: Нийгэмд гэмт хэрэгтэй тэмцэх ухамсрыг дээшлүүлэх, мэдээлэл солилцох боломжийг нэмэгдүүлэх.

- **Хамтын ажиллагаа**

- Бизнесийн байгууллагууд: Санхүүгийн байгууллагууд, компаниудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох.
- Төрийн бус байгууллагууд: Төрийн бус байгууллагуудын дэмжлэг, хамтын ажиллагааг сайжруулах.

зэрэг аргачлалыг ашиглан хүн худалдаалах гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг олж тогтоох, хураан авах, хохирогчдод нөхөн төлбөр олгох боломжтой.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгох нь хохирогчдын эрхийг хамгаалан сэргээхэд чухал ач холбогдолтой.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭЖ ОЛСОН ХӨРӨНГӨ, ОРЛОГООР ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЖ БУЙ ПРАКТИКТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ХОХИРОГЧИД УЧИРСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ ҮҮДНЭЭС ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС БИЙ БОЛСОН ХӨРӨНГӨ, ОЛСОН ОРЛОГЫГ ОЛЖ ТОГТООХ, ХУРААХ, БИТҮҮМЖЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 6.2-р зүйлийн 2.5 дахь хэсэгт заасны дагуу мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох, мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрөл авахаар зааснаас бусад тохиолдолд бие даан явуулдаг.

Мөн хуулийн 21.2 дугаар зүйлд заасны дагуу яллагдагч, шүүгдэгчийн хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ авахаас өмнө тэдгээрийг олж илрүүлэх, эрэн хайх, үзлэг шинжилгээ хийх зэрэг олон аргыг ашигладаг.

Мөрдөн шалгах болон шүүх хуралдааны явцад нотлох баримтыг шинжлэн судлах дараах аргуудыг хэрэгжүүлэх ёстой гэж үздэг. Үүнд;

- Мэдээлэлд тулгуурлан шалгах арга
 - o Хүн худалдаалах хэргийг шалгаж байгаа мөрдөгч болон шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарын мэдээлэлд үндэслэн хохирол барагдуулах, нөхөн төлбөр олгох ажиллагааны явцыг судлан гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлогыг хэрхэн олж тогтоож, тэдгээрийг хохирол барагдуулахад ашиглаж чадаж байгаа эсэх зэрэг асуудалд анхаарлаа хандуулсан.
- Баримтад үндэслэн шалгах арга
 - o Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хохирогчоос болон бусад этгээдээс өгсөн мэдүүлэг, эх сурвалж, мөн ажиллагааны үед олж тогтоосон хөрөнгө, орлогын талаарх баримтын үндэслэлийг шалгаж тогтоох ажиллагааны явцын талаар мэдээлэл авсан.

- Нотолгоонд тулгуурлан явуулах арга
 - o Хохирогчид учирсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулахтай холбоотой нотлох баримтуудыг хэрэгт хавсаргах, тэдгээр баримтын эх сурвалж, олгосон эрх бүхий мэргэжлийн байгууллагын нотолгоо, баталгаажуулалт, хугацаа, төлбөрийн хэмжээ зэргийг үндэслэлтэй тогтооход чиглэгдсэн ажиллагаанууд хийх, нотлох баримтын шаардлага хангасан мэдээллийн эх сурвалж, тэдгээрийн үнэн зөв эсэхийг нотолгоонд тулгуурлан шинжлэн судалж, өөр бусад нотлох баримтаар давхар батлагдаж байгаа эсэх, нотлох баримтаар ирсэн бичгийн болон бусад баримтын талаар дүгнэлт хийх зэрэг ажиллагаанууд хийгддэг.
 - o Энэ төрлийн гэмт хэрэг нийтэд ил бус нууц, далд байдлаар үйлдэгддэг тул хэрэг үйлдэгдсэн хугацааг нарийн тогтоох боломж маш бага байдаг. Хохирогчид нь ихэвчлэн насанд хүрээгүй хүүхдүүд байдаг учраас гэмт хэрэг үйлдэгдсэн он, сар, өдрийг нарийн сайн санадаггүй, мөн холбогдогч болон зарим гэрч нарын мэдүүлгээр өгсөн хугацаатай ихэнхдээ таардаггүй бөгөөд хугацааг нарийн тогтоох боломжгүйд хүрдэг. Түүнчлэн хохирогч талын мэдүүлгийг нотлох гэрч маш ховор байдаг бөгөөд дийлэнх гэрчүүд нь тухайн үед хамт байсан мөн л насанд хүрээгүй хүүхдүүд байдаг тул гэмт хэрэг үйлдэгдсэн хугацааг тогтоох нь ихээхэн хүндрэлтэй.
 - o Насанд хүрээгүй хохирогчид тодорхой өдөр, сараа санахгүй байдаг бөгөөд нийтээр тэмдэглэдэг баяр ёслолоор бус харин хэн нэгний төрсөн өдрөөр баримжаалсан мэдүүлгийг өгдөг.
- Бодит байдалд үндэслэн шалгах арга
 - o Хийсвэр, батлагдаагүй, эхүүсвэр тодорхойгүй, бусад байдлаар давхар нотлогдоогүй баримтад бус нотлогдсон, цаашид ач холбогдол бүхий баримт, бодит байдалд үндэслэн шалгаж, төлбөр хохирлын хэмжээг тогтоодог.
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах арга
 - o Тогтоох ажиллагаа нь батлагдсан хууль тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гаргасан заавар, дүрэм, журмуудад үндэслэгдсэн байхыг шаарддаг.
- Цахим системийг ашиглан шалгах арга
 - o Байгууллага хоорондын хамтын ажиллагаа болон нийтэд ил мэдээллийг шалгах арга нь баталгаатай, цаг хугацаа

хэмнэсэн ажиллагаа бөгөөд цахим системд буй мэдээллийг ашиглах, хуваалцах зэргээр нөхцөл байдлыг тогтоох зэрэг ажиллагаануудыг хийж, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг тодруулдаг.

Дээрх ажиллагаануудыг хийсний үндсэн дээр мөрдөгч олж тогтоосон хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрийн дагуу хийж битүүмжилдэг. Битүүмжилж байгаа хөрөнгийг бусдад шилжүүлэх, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглоод өөрт нь болон бусад боломжтой хүнд хариуцуулан хүлээлгэж өгөх ба хууль сануулж гарын үсэг зуруулах ажиллагааг хийдэг⁵.

Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгийг олж тогтоох, битүүмжлэх, хураах ажиллагааны эрх зүйн орчин хангалттай байдаг. Гэхдээ бидэнд зөвхөн ХХГХэрэгтэй холбоотой хөрөнгийг олж тогтоох ажиллагаа гэж байхгүй. Бүх гэмт хэрэгт хуулиар тогтоосон нийтлэг зохицуулалтын дагуу холбогдох ажиллагааг хийдэг. Мөн түүнчлэн Мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлж, эрүүгийн хэрэг үүсгэж байж хөрөнгө орлогыг олж тогтоох хэрэгтэй болдог. Тухайлбал холбогдогчийн нэр дээрх банкны дансанд үзлэг хийхдээ сэжигтэй бүх гүйлгээг нь асууж шалгах хэрэгтэй байдаг тул дансны хуулгыг нь авч дүн шинжилгээ хийсний дараа хохирлын хэмжээг тодорхойлох боломжтой болдог.



Жишээ – 1

Судалгаанд оролцсон мөрдөгчийн ярианаас.

Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах явцад эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хамгаалах, хадгалах, шилжүүлэх, шийдвэрлэхдээ баримтлах хуульд заасан журмын дагуу мөрдөн шалгах эрх бүхий байгууллага хураан авсан эд мөрийн баримтыг тухайн хэргийг хаасан, хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд хариуцан хадгалдаг нь хууль ёсны зарчимд нийцсэн байна.

Гэтэл хэргийг шүүхээр хэлэлцэх явцад мөрдөн шалгах ажиллагааны үед хийсэн зарим ажиллагааг хохирогч, холбогдогч нар хүлээн зөвшөөрөхгүй байх явдал шүүх хурал дээр ажиглагддаг. Энэ тохиолдолд шүүх хохирогчийн болон бусад оролцогчийн мэдүүлгийг үндэслэн хэргийг шийдвэрлэдэг боловч дуу дүрсний бичлэгээр баталгаажуулсан баримтаа хавтаст хэрэгтэй хамт ирүүлдэггүй байна.



Жишээ – 2

Судалгаанд оролцсон мөрдөгчийн ярианаас.

Эрүүгийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шилжүүлэх, шийдвэрлэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорын хамтарсан захирамж, тушаалаар баталсан “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны хөрөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”⁶ баримталж, хэргийн ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлж, гэрэл зургийн үзүүлэлт үйлдэн, үзлэгийн тэмдэглэлд хавсаргадаг. Харин шаардлагатай тохиолдолд дуу- дүрсний бичлэг хийн, цахим хэрэгсэлд хуулбарлан авах ба хураан авсан эд зүйлийг нотлох баримтын ач холбогдолтой гэж үзвэл эд мөрийн баримтаар тооцох тухай тогтоол үйлдэж, хавтаст хэрэгт хавсаргах тус журамд тодорхой заасан бөгөөд журмын хэрэгжилтийг практикт хангах шаардлагатай байна.

Овор хэмжээ ихтэй, тээвэрлэлтийн явцад гэмтэх, устах, бусад шалтгаанаар шилжүүлэх боломжгүй эд мөрийн баримт, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шүүх, прокурорын шийдвэрээр байгаа газарт нь битүүмжлэн тэмдэглэл үйлдэж, гэрэл зураг, дуу-дүрсний бичлэг хийн бэхжүүлнэ.

Эд мөрийн баримтыг хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх ажиллагаанд мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын дарга хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган улирал бүр тооллого явуулна... гэж зохицуулсан байна.

Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулдаг

⁶ Монгол Улсын Дээд Шүүхийн албан ёсны цахим хуудас [supremecourt.mn](https://www.supremecourt.mn), үзэх- <https://www.supremecourt.mn/mn/home?page=law&id=89&pr=19&tp=detail&cid=3>

ба хэмжээ нь хохирлын үнийн дүнгээс илүү гарвал улсын төсөвт шилжүүлдэг.

Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдвол түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.⁷

Хэрэв гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бол шүүх тухайн эд зүйлийг үнэлж, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос нь албадан гаргуулж хохирлыг төлүүлдэг.⁸

Харин тухайн хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон гэдгийг мэдсээр байж авсан бол шүүх бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, хөрөнгө, орлогыг хураан авч хохирлыг нөхөн төлүүлдэг байна.⁹

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын шатанд хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйл, эд мөрийн баримтыг бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэхтэй холбоотой харилцааг дээрх журмаар зохицуулна.¹⁰

Журамд зааснаар хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл хадгалах бөгөөд мэргэжлийн байгууллагын болон шинжээчийн дүгнэлтээр хадгалах боломжгүй нь тогтоогдсон бол прокурор зохих байгууллагад шилжүүлэх тухай санал гаргаж шүүхэд хүргүүлэх ба хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг зориулалт, хэрэгцээнийх нь дагуу зохих байгууллагад шилжүүлэх тухай прокурорын саналыг хүлээн авсан шүүгч захирамж гаргаж шийдвэрлэхээр тус тус заасан.¹¹

Дээрхээс үзвэл гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах явцад эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хамгаалах, хадгалах, шилжүүлэх, шийдвэрлэхдээ холбогдох журмын дагуу Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага хураан авсан эд мөрийн баримтыг тухайн хэргийг хаасан, хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэр хүчин

⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 4 дахь хэсэг

⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 4 дахь хэсэг

⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг

¹⁰ “Эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, эд зүйлийг хураан авах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх” журам 2021 онд батлагдсан.

¹¹ Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан 2019 оны 12-р сарын 05-11 ны өдрийн дугаар 246/А80 захирамж, тушаалын хавсралтаар батлагдсан “Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, барьцааны хөрөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”-ын 8.1, 8.2 дахь хэсэг.

төгөлдөр болох хүртэлх хугацаанд хариуцан хадгалдаг нь хууль ёсны зарчимд нийцсэн байна.

Шүүхээс хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг зохих байгууллагад хадгалуулахаар гаргасан шийдвэрийг мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлж, прокурор хяналт тавина. Түүнээс гадна хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, эд мөрийн баримтыг шинжээчийн болон мэргэжлийн байгууллагын дүгнэлт, бусад нотлох баримтуудыг үндэслэн худалдан борлуулж, орлогыг хүүгүй, тусгай дансанд хадгалах болон зарим эд мөрийн баримт, хөрөнгийг устгуулахаар зохих байгууллагад шилжүүлэх прокурорын саналыг хүлээн авсан шүүгч захирамж гаргаж шийдвэрлэнэ.

Эрүүгийн хэрэгт хураан авсан хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримт, эд зүйлийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналтын явцад хүлээн авах, хадгалах, хамгаалах, шилжүүлэх ажиллагааг Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталсан заавар, журмаар зохицуулдаг.

Мөрдөгч болон прокурор, шүүгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2, 1.3, 1.4-д заасан ажиллагааг явуулахдаа хохирол, төлбөртэй холбогдох хөрөнгө орлогоос бусад хуульд заасан арга журмын дагуу олж авсан, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой, тухайн этгээдийн гэм буруутай эсэхийг тогтооход зайлшгүй хэрэгтэй мэдээлэл агуулсан, бодит байдлаар нь дахин сэргээх боломжгүй, нотлох баримтад үнэлэгдэх эд мөрийн баримтыг эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл биет байдлаар нь хадгалах бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1, 16.4, 16.14, 16.15 дугаар зүйл, холбогдох заалтуудыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахгүй байхад анхаарах ёстой” гэсэн байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч нар дээрх журмын дагуу ажиллагаа хийхийн тулд гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө орлого болон хохирол, төлбөрийн талаар тодорхой мэдээллийг баримтжуулсан байх ёстой

Хохирол барагдуулахад чиглэсэн хөрөнгийг олж тогтоосны дараа төлбөр барагдуулах ажиллагаа бараг хийгдэхгүй байгаа. Учир нь бид шүүхээр эцэслээгүй байхад хохиролд тооцож, шилжүүлэх боломжгүй байдаг. Хохирогчийн мэдүүлгийн дагуу гэмт хэргийн улмаас олсон орлого, ашгийг тогтоохоор бид ажилладаг, Прокуророос биднийг шалгаад давхар “Мөнгө угаах гэмт хэргийн шинж байна уу”... гээд гарал үүслийг нь тогтоо гэж шаарддаг.



Жишээ – 3

Судалгаанд оролцсон мөрдөгчийн ярианаас.

Гэвч хохирогч болон түүний хууль ёсны төлөөлөгч нар “хохирол нэхэмжлэхгүй, гомдол санал байхгүй” гэсэн боловч мөрдөн шалгах ажиллагааны явцад “тэр миний гар утсыг авсан, миний олсон орлогыг авсан, машинаа сольж сайжруулсан” гэх мэтээр мэдүүлсний үндсэн дээр мөрдөгч нар холбогдох ажиллагааг хийдэг.

Олон улсад хэмжээнд гадаадын зарим орнууд гэмт хэргийн улмаас олсон орлогыг хураах нь цаашид хууль бус гэмт хэрэг гарахаас сэргийлэхэд ач холбогдолтой гэж үздэг байна. Тухайлбал:

1. Канадын эрүүгийн хуулийн 462.3-д гэмт хэргийн улмаас олсон орлого, эд хөрөнгийг хураан авах тохиолдолд прокурорын саналаар шүүгч тухайн эд хөрөнгийн өмчлөл, эзэмшилд хориг хязгаар тавьж болно. Шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд тухайн эд хөрөнгийг худалдан авах, бэлэглэх болон шүүхийн захирамжид заасан хэлбэрээр шилжүүлэхийг хориглодог.
2. АНУ-д эд хөрөнгө хураах ажиллагаанд нэгдсэн улсын маршалын алба нь ХЗДХЯ-ы агентлагийн хураан авсан эд хөрөнгийг хариуцдаг.

Зарим асуудлыг Сангийн яам нь хариуцдаг ба тухайн байгууллагууд уг эд хөрөнгийг дуудлага худалдаагаар хувийн секторт зарж, цэвэр ашгаар нь хууль сахиулах үйл ажиллагаагаа санхүүжүүлдэг байна. Хөрөнгө хураах ажиллагаа нь

- Эрүүгийн журмаар хөрөнгө хураах
- Иргэний журмаар хөрөнгө хураах 2 гэсэн янз байдаг.

Эд хөрөнгө хураах нь аль илүү нотлох баримт цуглуулсан буюу аль нэг илүү үнэн болохыг нотолсон талд нь шүүх хэргийг шийдвэрлэх зарчимд үндэслэгддэг. Иргэний журмаар эд хөрөнгө хураах ажиллагаа нь эрүүгийнх шиг шийтгэх шинжтэй бус хохирол нөхөн төлүүлэх

шинжтэй байдаг. Харин Иргэний процесс ажиллагаанд АНУ-ын Засгийн газар нэхэмжлэгчээр оролцох ба тухайн хөрөнгийг хураан авах үндэслэлийг нотлох үүрэг хүлээдэг байна.

3. Серби улсад гэмт хэргийн улмаас бий болсон орлого, ашгийг хураан авах нь тухайн эд хөрөнгө, ашиг орлого өөр гэмт хэрэг үйлдэх, гэмт бүлэглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээс сэргийлэх ач холбогдолтой гэж үздэг ба “Гэмт хэргээс олсон орлого, эд хөрөнгийг хураан авах тухай” хуулийг батлан гаргасан байна.

Энэ хуульд зохион байгуулалттай гэмт хэрэг, насанд хүрэгчдийн видео садар самуун бичлэгийн эсрэг болон хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс олсон аливаа орлого, эд хөрөнгийг хураахаар заасан. Хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг шалгах, хураан авах ажиллагааг прокурор, шүүх, Дотоод хэргийн яамны санхүүгийн тагнуулын алба болон тухайн хураан авсан эд хөрөнгийг хадгалах, хамгаалах үүрэг бүхий байгууллагууд хариуцдаг. Санхүүгийн тагнуулын алба нь гэмт хэргээс олсон орлого, эд хөрөнгийг илрүүлэх үүрэг хүлээдэг ба хөдлөх үл хөдлөх хөрөнгө, хууль бус орлого, амьжиргааны зардал, гуравдагч этгээдэд шилжүүлсэн болон бусдад өв залгамжлуулан эд хөрөнгөд санхүүгийн мөрдөх ажиллагаа явуулж, дүгнэлт гаргадаг. Санхүүгийн мөрдөх ажиллагааг прокурор удирддаг. Орон байр, байшин барилгад нэгжлэг хийх тохиолдолд шүүхийн зөвшөөрлийг авсан байх бөгөөд хэрэв тухайн эд хөрөнгийг захиран зарцуулах, бусдад шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал эд хөрөнгийг түр хураан авах, үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэхийг хориглосон шийдвэр гаргадаг байна.¹²

4. АНУ, Филиппин улсууд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид Засгийн газраас нөхөн олговор олгодог байна.

5. Филиппин улсад уг нөхөн олговор дээр нэмэгдэн хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч хохирогчид төлөх нөхөн төлбөр олгохоор хуульчилсан. Мөн Филиппин улс хохирогчийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлгүй болсны дараа мэдүүлэг авах, хүүхдийг дахин сэтгэцийн гэмтэл авахаас урьдчилан сэргийлэх зорилгоор харилцан тохиролцож гэм бурууг хүлээлгэх аргыг шүүхийн шатанд ашигладаг.

6. БНСУ нөхөн төлбөр авахын тулд иргэний хэрэгт гомдол гаргах зохицуулалттай. Тус улс насанд хүрээгүй хохирогчийг биеэр оролцуулахгүйгээр видео болон бусад цахим аргаар гэрчийн мэдүүлэг авах, эцэг эх, асран хамгаалагчтайгаа мэдүүлэг өгөхийг зөвшөөрдөг.

¹² ХЗҮХүрээлэн “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнтэй тэмцэх асуудал”

Дээрх туршлагыг үндэслэн Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй ажиллагааны шат бүрд хохирол барагдуулах ажиллагаа хэрхэн хийгдэж байгааг судлан тодорхойлж, дүгнэлт гаргах зорилгын үндсэн дээр Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг онцлон авч үзсэн ба гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө орлогыг олж тогтоох, хураах, битүүмжлэх ажиллагааны явцыг тодруулахаар ажилласан.

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна гэж 2017 оны 5 дугаар сарын 11-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан.

Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулдаг.

Бразил улсад 2010 оны 4-р сард зохион байгуулагдсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба ЭБША-ны талаарх НҮБ-ын 22 дугаар конгрессоос гаргасан тунхаглалын 5-д **...Хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх, дахин хохирогч болохоос хамгаалах**, үндэсний хууль тогтоомжийг батлан гаргахын чухал-ыг тэмдэглэхдээ хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлыг, мөн зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, терроризмын гэмт хэргийн хохирогчийн асуудалд анхаарахыг уриалсан.

Мөн Эрүүгийн эрх зүйн хүрээнд болон ЭБША дахь хохирогчийг хамгаалах талаарх зөвлөмж нь хохирогчийн шүүхэд итгэх итгэл үнэмшлийг бэхжүүлэхэд чиглэгдсэн байдаг. Энэ баримт бичгээр хохирогчид учрах бие махбод, сэтгэл санаа, эд хөрөнгө болон нийгэмд учруулах хохиролд анхаарлаа хандуулж, энэ талаар хамгаалах бүх арга хэмжээг улс гүрнүүд **Байцаан шийтгэх ажиллагааны бүх шатанд** авах ёстой гэж уриалан хохирогчийг хамгаалах үндсэн зарчмыг баталсан.

Олон улсын хамтын нийгэмлэгээс энэ баримт бичигт заасан стандартуудыг нэгтгэн жишиг тогтоохдоо хохирогчийн эрхийг хамгаалах, хохирол, нөхөн төлбөрийг барагдуулахтай холбоотойгоор

- Гэрч, хохирогчийг хамгаалах төрийн бодлогыг боловсруулах
- Холбогдох хууль тогтоомж гаргах

- Хууль сахиулах байгууллагын ажилтны зүгээс гэрч, хохирогчтой ажиллах дүрэм боловсруулж мөрдөх.
- **Хохирогчдод туслалцаа үзүүлэх албыг бэхжүүлэх**
- **Гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэх хөрөнгө зарцуулах механизм бүрдүүлэх**
- Нөхөн олговрын механизмыг бүрдүүлж, тусгай зориулалтын сан байгуулах
- Тодорхой гэмт хэргийн төрлөөс шалтгаалан гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах. Тухайлбал: Зохион байгуулалттай гэмт хэрэг, Хүний наймаа, терроризмын гэмт хэргийн хохирогчийн асуудалд анхаарах
- Хохирогч хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлыг онцгой анхаарах
- Аюулгүй байдлын үүднээс шүүх хуралдааныг хаалттай явуулах боломж бүрдүүлэх
- Шаардлагатай мэдээллээр хангах / эрх зүйн болон бусад туслалцаа, төрөө болон гэм буруутнаас **хохирлыг барагдуулах боломжийн** талаарх мэдээлэл гэх мэт/
- Хохирогч шүүх хурал хэзээ, хаана, яаж явагдах, хохирлыг барагдуулах, нөхөн олговор гаргуулах боломж, байцаан шийтгэх ажиллагааны үр дүнг мэдэх эрхийн туслалцаа, бусад аргын талаар **шүүхээс мэдээлдэг байх.**
- Нөхөн олговор нийгмийн халамжид хамруулах
- Хохирогчоос мэдүүлэг авахдаа түүний хувийн байдал, нэр хүнд, эрхийг хүндэтгэдэг байх
- Хохирогчийн **хохирол барагдуулах асуудлыг шийдвэрлэсний дараа гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх** эсэхийг шийдвэрлэдэг байх
- Хохирогчийн хувийн амьдрал, нэр хүнд хөндөгдөх аливаа баримт, мэдээллийг тараахаас хамгаалах
- Гэмт этгээдийн өс хонзон, айлган сүрдүүлэлтээс хамгаалах асуудлууд юм гэжээ.

ХОЁР. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ АЖИЛЛАГААНЫ ШАТ БҮРД ХОХИРОЛ БАРАГДУУЛАХ АЖИЛЛАГАА ХЭРХЭН ХИЙГДЭЖ БАЙГАА ТАЛААРХ СУДАЛГАА

Судалгаанд оролцогчид (судалгааны удиртгал хэсэгт дурдсан шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнууд болон мөрдөгчид) бүгд *“гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлогыг олж тогтоох ажиллагааны эрх зүйн орчин үнэхээр хангалттай хэмжээнд байгаа”* талаар дурдаж байсан ба гагцхүү хохирогч нар л мэдүүлгээ тодорхой зөв өгөх шаардлагатай байдаг тул мөрдөгчид хохирол төлбөрийн талаар тодруулж асуусан мэдүүлэг авдаг.

Хохирол төлбөрийн баримтаа гарган өгсөн тохиолдолд холбогдогчоос хохирлоо гаргуулах боломжтойг мэдсэн, ойлгосон, мэдээлэл бүрэн авсан хохирогчийн сэтгэл ханамж дээшилснээр мөрдөгчдөө итгэх, илэн далангүй ярилцах, мэдүүлгээ сайн өгөх, нээлттэй харилцах, гэмт үйлдлийг болон болсон асуудлыг нуухгүй байх зэрэг эерэг үр дүн гарах боломжтой юм.

Эрчүүд ихтэй газарт энэ гэмт хэрэг их үйлдэгдэж байна. Хөдөө интернэтгүй учир бэлнээр авдаг болохоор хохирлыг нь бүрэн тогтоогдох боломжгүй байдаг. Хөдөө орон нутагт байгаа хэргийг шалгах гэхээр өөрөө явах боломжгүй, орон нутгийн цагдаад даалгадаг ч тэд нэгдүгээрт: ХХГХ-ийн талаар сайн мэдэхгүй, хоёрдугаарт: Орон нутгийнхан ихэнх нь ах дүү хамаатан садан байх магадлал өндөр учир байцаалтыг үр дүнтэй сайн авдаггүй, гол гол асуудлыг орхигдуулдаг талтай.

Насанд хүрээгүй зарим хохирогчид эрхийг нь тайлбарлаж хэлсэн ч “өө яахын бэ”, эсхүл “яршиг яршиг”, “за тэр ч яах вэ нэг л гар утас” гэх мэтээр цааргалан нэхэмжлэх дургүй байдгаас гадна өөрийн эд хөрөнгийнхөө үнэ цэнийг үл тоодог тал их ажиглагддаг. Харин хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, эцэг эх нь хохирлын төлбөрөө гаргуулахыг хүсдэг ч гомдол санал, өргөдөл хүсэлт бичих дургүй байдаг.

Судалгаанд оролцсон мөрдөгчийн ярианаас.



Жишээ – 4

Цаашид учирсан хохирол, нөхөн төлбөрийн талаар хэрхэн мэдүүлэг авах, авсан мэдүүлгээ хэрхэн баримтжуулах, нотлох баримт бүрдүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас олсон орлого, эд хөрөнгийг тодруулан шалгах, битүүмжлэх, хураах, шинжээч томилох, үнэлгээ тогтоох, тэдгээрийг хохирогчийн хохирлыг нөхөн төлөхөд чиглүүлэх зэргээр холбогдогчийг бусдад учруулсан

хохирол төлбөрөө сайн дураар төлөх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Эсхүл тэдгээр хөрөнгийг төлбөрт тооцох, хохирол төлбөрийг гаргуулах зэргээр хохирогчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажиллагааны заавар, зөвлөмжийг тодорхой давтамжтайгаар мөрдөгч болон холбогдох бусад ажилтнуудад өгөх шаардлагатай байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад насанд хүрээгүй хохирогчийн гомдол, хүсэлт, санал бодлоо илэрхийлэх бололцоог олгож, онцгойлон анхаарч үзэх, хэргийг шуурхай шийдвэрлэх, хохирогч, гэрчээр мэдүүлэг өгсөн хүүхдийн хувийн амьдралын нууцыг хамгаалах, шаардлагатай тохиолдолд дарамт, шахалт үзүүлэх, өш хонзон авах, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авсан эсэхэд анхаарна гэж УЕПГазраас гаргасан зөвлөмжид¹³ дурдсан байна.

Жишээ – 5.

Хохирогч нараас байцаалт авахдаа хохирол төлбөрийн талаар нь асуудаг. Эд хөрөнгийг нь хүн аваад явсан бол нэхэж гаргуулах, эрүүл мэндэд учирсан хохирлыг нь гаргуулах, төлүүлэх, сэтгэл санааны хохирлын дүгнэлт гаргуулах зэргээр ажилладаг. Өгсөн баримтыг нь үдэж хавсаргадаг. Хохирол төлбөрийн тухай нь бид асуултаараа тодруулж, тэмдэглэж авдаг.

Жишээ – 6.

... Бид эрүүгийн хэрэг үүсэхээс эхлээд гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг тогтоох ажиллагааг хангалттай сайн хийдэг. Харин хохирогч нар ямар арга замаар хохирлоо нэхэмжлэх, ямар баримт бүрдүүлэх, хэрхэн хэнд хандах зэргээ мэдэхгүй байх, мэдээлэлгүй байх зэрэг олон шалтгааны улмаас гомдол гаргадаггүй. Энэ асуудлыг зөв хэрэгжүүлээд сурчихвал хэрэгтэй санагддаг. Сүүлийн үед сэтгэл санааны хохирлыг тогтоодог болсон нь сайн тал болсон.

Судалгаанд оролцсон мөрдөгчийн ярианаас.



¹³ “Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн насанд хүрээгүй гэрч, хохирогчтой сэтгэцийн гэмтэлд суурилсан хандлагаар хэрхэн харилцах, тэдгээрээс мэдүүлэг авахад анхаарах асуудлын зөвлөмж”

Үүнээс үзвэл ХХГХ-ийн хохирогчид өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх боломжийг эрх зүйн орчинд бий болгосон хэдий ч тэдэнд хохирол төлбөрөө нэхэмжлэх, шаардах эрхийг нь тайлбарлах, холбогдох мэдээлэл өгөх асуудал хангалтгүй байна.

ХХГХ-ийг хянан шийдвэрлэх явцад дан ганц өмгөөлөгч төдийгүй мөрдөгч, прокуроруудын зүгээс энэ асуудалд онцгой анхаарч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн шаардлага тавих хэрэгтэй байна. Хохирол, нөхөн төлбөрийг барагдуулах асуудал дан ганц хохирогчид хамааралтай бус, холбогдогчид ч эергээр нөлөөлөх хууль зүйн үндэслэлтэй тул бүх хуульчид хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 11-р сарын 20-ны өдрийн А/399 дүгээр тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ыг баталсан бөгөөд тус журамд эрүүгийн хэрэг үүсгэж, хохирогчоор тогтоосон эсэхээс үл хамааран хүн худалдаалах гэмт хэргийн улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулахаар тусгасан байна.¹⁴

ХХГХ-ийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журамд зааснаар арван найман насанд хүрээгүй хохирогч хүүхдэд түүний эцэг, эх, харгалзан дэмжигч, асран хамгаалагч, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгчийн гаргасан хүсэлтийг үндэслэн хүүхдийн асуудлаар мэргэшсэн, дагнасан улсын өмгөөлөгчөөр хууль зүйн туслалцаа үзүүлэх, 14-18 насны хохирогч хүүхэд өөрөө хүсвэл хууль зүйн туслалцаа үзүүлнэ. Хохирогч хүүхдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ түүний эрх ашгийг хуульд заасны дагуу төлөөлж, хүүхдийн сэтгэл зүй, насны онцлогийг анхааран үзэх зэрэг онцлог зохицуулалтуудыг тусгажээ.

Мөн журамд зааснаар энэ чиглэлийн төрийн бус байгууллагын хувьд хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхдээ дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

- ✓ Хохирогчид ямар туслалцаа авах боломжтойг нэг бүрчлэн тайлбарлаж, үнэн зөв мэдээлэл өгөхийг хохирогчид ойлгуулах;

¹⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 11-р сарын 20-ны өдрийн А/399 дүгээр тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”-ыг батлан хэрэгжүүлж байна. үзэх <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960401473551>.

- ✓ Хүн худалдаалах гэмт хэрэгт дахин өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгөх;
- ✓ Хохирогчийн эрх, ашиг сонирхлыг хангахад хуульд заасны дагуу төлөөлөх;
- ✓ Хууль зүйн туслалцаа үзүүлдэг байгууллага, албан тушаалтантай холбох.
- ✓ Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон дахин өртөхгүй байх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах
- ✓ Хохирогчийн нэр төрд халдсан мэдээ, мэдээллийг түгээх, ашиглахгүй байх
- ✓ Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон дахин өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө, мэдээллийг монгол, англи хэлээр байгууллагынхаа цахим хуудсанд байршуулан олон нийтэд түгээх зэрэг ажиллагааг явуулахыг тухайлан журамласан.

Энэхүү журмыг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Хууль зүйн туслалцааны тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн 2023 онд батлан гаргасан¹⁵ бөгөөд цаашид улс орон даяар хэрэгжилтийг хангаж ажиллах нь энэ төрлийн харилцаанд онцгой ач холбогдолтой.

Өмгөөлөгчийн оролцоог сайжруулах

Хүн худалдаалах гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа өмгөөлөгчийн эрх, үүрэг, оролцоог сайжруулах, түүний гаргасан хүсэлт, баримтад ач холбогдол өгөх нь хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хохирол төлбөрийг гаргуулах чухал хөшүүрэг болдог.

Судалгаанд оролцсон мөрдөгчийн ярианаас.



Жишээ – 7

¹⁵ Эрүүгийн хуулийн /Шинэчилсэн найруулга 2015/ -д

ХХГХ-ийн хохирогчийг эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхэд тэдний өмгөөлөгчийн үйл ажиллагааны баталгаа нэн чухал юм. ХХГХ-ийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өмгөөлөгчийн үүрэг, оролцоог сайжруулах, түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын яллагч, эсхүл шүүхийн зүгээс хохирогчийн өмгөөлөгчид шүүх хурлын товыг заавал мэдэгдэж, шүүх хуралдаанд оролцон хохирогчийн эрхийг хамгаалах, мэтгэлцэх боломжоор хангуулах шаардлагатай байх бөгөөд дараах хүндрэл бодитоор бий болж байна. Үүнд:

- ЭХХШТХуулийн 16.1 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт *"Хохирогч, яллагдагч тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурор авч хавтаст хэрэгт тусгаж хавсаргана...* гэж заасан учир дан ганц Хүн худалдаалах гэмт хэрэгт бус шалгагдаж байгаа бусад эрүүгийн хэрэгт өмгөөлөгчийн гаргасан санал хүсэлтийг хүлээн авахдаа зарим мөрдөгч нар хойрго ханддаг. Энэ нь тухайн мөрдөгчид өргөдөл хүсэлтийн хариуг нь бичиж өгөх, дахин ажиллагаа хийх зэрэг нэмэлт ажил хийх шаардлага гаргадаг тул тэд ачааллаа нэмэхгүй байх үүднээс хэрэгт хавсаргахгүй байх, ажиллагааг хийхгүй орхих зэрэг тохиолдол гардаг.
- Өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой буюу хууль зүйн туслалцаа авсан, өмгөөллийн хөлс төлбөр төлсөн баримт нь хохирогчид учирсан хохирлыг нотлох, учирсан хохирлын хэмжээг тогтооход чухал учраас нотлох баримтаар тооцохгүй байх аргагүй юм. Хууль зүйн туслалцааны хөлсний хэмжээ нь удаан хугацаанд шалгагдсан, эсхүл олон өмгөөлөгч сольж ажиллуулсан хэрэг дээр нэмэгдсэн байж болох учир хохирол төлбөрийг тогтоох бас нэгэн нотолгооны баримт юм.
- Өмгөөлөгчийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байхдаа хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгчид хэргийн талаарх мэдээллээс гадна хохирол төлбөрийг барагдуулахтай холбоотой мэдээлэл, шаардлага хангасан нотлох баримтыг гаргаж өгөхтэй холбоотой зэрэг чухал мэдээллүүдийг цаг алдалгүй өгөх, тэдгээрийг бүрдүүлэхэд зөвлөгөө өгөх, хамтран ажиллах шаардлагатай байна.
- Мөн шүүх хуралдаанд ХХГХ-ийн хохирогчийн өмгөөлөгчийг заавал оролцуулах талаар прокуророос шүүхэд санал оруулах, эсхүл яллах дүгнэлтэд заавал тусгаж өгөх хэрэгтэй байна. Хэргийг олон удаа буцааж, шийдвэрлүүлэх явцад тухайн хэрэг хэдийд

шүүхэд ирсэн, шүүх хурал хэзээ товлогдсон талаар хохирогчийн өмгөөлөгч нарт мэдээлэхгүй тохиолдол гардаг. Зарим шүүх хохирогч руу залгаад, *“чи ирээд хэрэггүй байх”* гэхээр хохирогч нь *“би очихгүй юм чинь өмгөөлөгч бас хэрэггүй байх”* гэж хэлсэн тохиолдол гарсан тухай яригдаж байсан. Иймд улсын яллагч, эсхүл шүүхийн зүгээс хохирогчийн өмгөөлөгчид шүүх хурлын товыг заавал мэдэгдэж, шүүх хуралдаанд хохирогчийн эрхийг хамгаалах ажиллагааг хийлгэх саналтай байна.

ГУРАВ. ХОХИРОЛ БАРАГДУУЛСАН, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХООР ШИЙДВЭРЛЭСЭН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Шүүхийн шийдвэрт хийсэн түүвэр судалгаанаас харахад Хүн худалдаалах гэмт хэргийн эд мөрийн баримтаар ихэвчлэн автомашин бүртгэгдэн хураагдаж, шүүхийн шийдвэрээр улсын орлого болгосон байх ба зарим тохиолдолд автомашиныг нь хураахгүйгээр түүний үнийг гаргуулан улсын орлого болгохоор шийдвэрлэсэн байна. Ганцхан тохиолдолд л хохирогчийн гар утсыг холбогдогчоос хураан авч, хохирогчид учирсан хохирлыг барагдуулсан байна.

ХХГХ-ийн хохирогчийн хувьд бүх шаардлагатай баримтыг бүрдүүлэн хохирлоо шүүхээр нэг мөр шийдвэрлүүлэх нь шүүхийн болон өөрсдийн цаг хугацааг хэмнэх, хохирлоо богино хугацаанд авах зэрэг олон ач холбогдолтой.

Хүснэгт 3. 2023 оны Эрүүгийн хэргийн тоо мэдээнээс.

Шилэн ажиллагааны хүрээнд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн мэдээлэл shilen.gov.mn системд байршиж, 2024 оны эхний байдлаар 484 мэдээлэл бүртгэгджээ

Тус сангаас 2022 онд хамгийн их буюу 493,282,317 төгрөг хохирогч нарт олгосон байсан ба сүүлийн 10 жилийн байдлаар нийт 2,648,945,962 төгрөгийн нөхөн төлбөр олгосон байх ба хамгийн их нөхөн төлбөрийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 91.1, 91.2- зүйл заалтаар шийтгүүлсэн 247 шийтгүүлэгчид олгожээ.


ХХГХ-ийн хохирогчид дээрх сангаас олгосон төлбөр байхгүй боловч шүүх хуралдааны шатанд зарим хохирлыг төлүүлж байсан билээ.

“Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, шүүхээс оногдуулсан ял, эмт хэрэг үйлдэгдэж буй шалтгаан нөхцөлийг 2021-2023 оны 1-р улирлын байдлаар улсын хэмжээнд нэгдсэн удирдамжийн дагуу судалсан” дүнгээс үзвэл:

Гэмт хэргийн улмаас 117 хохирогч жирэмсэн болсны 62,4 хувь нь насанд хүрээгүй хүүхэд байгаагийн 27,3 хувь нь 14 насанд хүрээгүй, бага насны хүүхдүүд байна.¹⁶

¹⁵ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан мэдээлэл. 2024 он

Хүснэгт 4. Гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын насны ангилал



Харин Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээллийн дүнгээс үзвэл:

Шүүхээс 22 этгээдэд хүн худалдаалахын эсрэг зүйл заалтаар ял оноосон ба эдгээрийн 13 хүнд Эрүүгийн хуулийн 12.3-р зүйлээр, 9 хүнд Эрүүгийн хуулийн 13.1-р зүйлээр тус тус ял оноосон байна.

Хүснэгт 5. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн иргэдийн тоон мэдээлэл



- Шүүх сүүлийн гурван жилд албадан хөдөлмөр эрхлүүлж хүн худалдаалсан асуудлаар нэг ч хэрэгт ял оноогоогүй (2019 онд 3 байсан).
- Шүүх мөн 13 этгээдэд Эрүүгийн хуулийн 16.8 ба 16.9-р зүйлээр ял оногдуулсан ба олон улсын тодорхойлолтын хэм хэмжээгээр хүн худалдаалсан гэх элементүүд байгаа эсэхийг баталгаажуулахад хангалттай баримтуудыг холбогдох байгууллагуудаас гаргаж өгөөгүй...гэсэн мэдээлэл гарсан байна.

Хүснэгт 6.Ял шийтгэлийн талаарх мэдээлэл

12.3 зүйлээр

- 13 этгээдийг
- 3-5 жилээр хорих ялаар

12.6 зүйлээр

- 16 этгээдийг тэнсэн харгалзах ялаар
- Нэг этгээдэд 3 жил хүртлэх хугацаагаар хорих ялаар

13.1 зүйлээр

- 9 этгээдийг
- 1- 8 жилийн хорих ялаар

16.8-16.9 зүйлээр

- 5 этгээдэд 6 сараас 3 жилийн хорих ялаар
- 4 этгээдэд торгуулийн ялаар
- 4 этгээдэд нийгэмд тустай хөдөлмөр эрхлүүлэх ял оногдуулсан байна.

Шүүхээс 2021-2022 онд Эрүүгийн хуулийн 12.3, 13.1, ба 16.8-р зүйлээр оногдуулах ял шийтгэлд 34 хохирогчид нийт 22,46 сая төгрөгийг (\$6,520) нөхөн төлбөрт олгохоор заасан. *(2021 онд гурван хохирогчид тодорхой дурдаагүй зүйл ангиар 3,6 сая төгрөг буюу 1,050 ам. доллар төлсөн байдаг).*¹⁷

¹⁷ Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан. 2023.09.13 – үзэх <https://mn.usembassy.gov/mn/2023-traffic-in-persons-report-mn/>

Хүснэгт 7. Гэмт хэргийн улмаас хохирогч нарт олгосон төлбөрийн мэдээлэл



Хохирогчид учирсан хохирлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад барагдуулах нь хохирогчийн цаг хугацааг хэмнэх, эдийн засгийн хэмнэлттэй байдаг тул дараа нь нотлох баримт бүрдүүлэн Иргэний хэргийн шүүхээр хохирол хор уршгийн нөхөн төлүүлэх шийдвэр гаргалгүйгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад, эрүүгийн хэргийн тогтоолын дагуу хохирлын асуудлыг нэг мөр шийдвэрлүүлэхийг эрхэмлэх шаардлагатай байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн, ялангуяа насанд хүрээгүй хохирогчийн хохирол төлбөрийг гаргуулах гүйцэтгэх хуудас, материал манайд ирж байгаагүй. Ер нь эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд шүүхийн тогтоолын дагуу хураасан, битүүмжилсэн хөрөнгийг улсын орлогод оруулах тохиолдолд иргэдээс санал, гомдол ирдэггүй. Манайд насанд хүрээгүй хүүхэдтэй холбоотой, хохирол барагдуулах мэдээ тайлан гардаггүй. Төлбөр авагч насанд хүрсэн байх ёстой, эсхүл насанд хүрээгүй хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийг томилсон байх ёстой байдаг.



Жишээ – 8

Судалгаанд оролцсон мөрдөгчийн ярианаас.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газарт ирсэн бүх л гүйцэтгэх хуудасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгддэг боловч насанд хүрээгүй хохирогчтой холбоотой хохирол барагдуулах ажиллагаа яагаад явагдахгүй байгаа талаарх шалтгаан нөхцөлийг илүү тодруулж, ХХГХ-ийн хохирогч болон насанд хүрээгүй хохирогч хүүхэдтэй холбоотой ажиллагааг тусгайлсан шийдвэр гүйцэтгэгчид хариуцуулах, ХХГХ-ийн бусад гэмт хэргээс онцлог нөхцөл байдал,

ялгамжтай байдлыг харгалзан үзэж, энэ чиглэлээр ажиллах мэргэшсэн ажилтнуудыг шийдвэр гүйцэтгэх байгууллага бэлтгэх шаардлагатай гэж үзэж байна.

Мөрдөгч нар хохирогчид шаардлагатай хоол ундны, унааны, ахуйн хэрэглээний зардал, эмэгтэй хүний ариун цэврийн хэрэглэл /дамск/ зэрэг амин чухал, наад захын хэрэгцээний зардлыг бид өөрсдөөсөө гаргасан. Ер нь ажлаа албаны болон хувийн тэргээр зохицуулдаг. Мэдүүлэг авахын тулд Багануур болон Налайх дүүрэгт байгаа хохирогч нарыг авчрах зардлыг нь хувиасаа гаргадаг. Учир нь хохирогч нар зардалгүй гээд байцаалтад ирэхгүй байх хандлага гаргадаг. Ирэх, буцах унааны 2 талдаа 30,000 төгрөгийн зардлыг нь би хувиасаа 5 удаа гаргасан. Дээр нь насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авах гэхээр “өлсөөд байна, хоол идье гэдэг. Ингээд 150,000 - 200,000 төгрөгийн зардал гаргасан удаатай”. Энэ хэрэгцээг нь хангахгүй бол хохирогч нар байцаалтад ирдэггүй. Хохирогч нарын ихэнх нь 14-16 насныхан байдаг. Тэд хот мэдэхгүй учир байх айл, ах дүүд нь хүргэж өгөх тохиолдол ч байгаа. Энэ бүхнээс харахад хохирогчид чиглэсэн үйл ажиллагааны зардал гэж манайд байхгүй. Ийм зардал гаргадаг болмоор байна. Хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн сэтгэл санааны болон бие махбодын хохирол, бусад шаардлагатай зардлыг улсаас гаргамаар байна. Шинээр сэтгэл санааны хохирол гаргуулах журам хэрэгжсэн ч их удаан байна.



Жишээ - 9

Судалгаанд оролцсон мөрдөгчийн ярианаас.

Монгол улсын Засгийн газрын 2011 оны 132 дугаар тогтоолоор “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам” хэрэгжиж байгаа боловч Гэрч, хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас хохирогчид нөхөн төлбөр олгохоор зөвшөөрөгдсөн Эрүүгийн хуулийн зүйл ангийн жагсаалтад ЭХ-ийн 13.1 дүгээр зүйл ороогүй байсан.

Харин Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг 2019 онд шинэчлэн баталж, 2020 онд “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам”-ыг баталсан ба Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлтийн 10.2 дахь хэсэгт заасан эх үүсвэрээс бүрдсэн Сангийн хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, Эрүүгийн хуульд заасан дор дурдсан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн хууль ёсны төлөөлөгч, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгоход зарцуулахаар журамласан.¹⁸

¹⁸ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 220 дугаар тогтоолын хавсралт, “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам”, үзэх - <https://legalinfo.mn/mn/detail?law-Id=16123495495401>.

Хүснэгт 8. Засгийн газрын тусгай сангаас нөхөн төлбөр олгогдох гэмт хэргийн зүйл ангиуд.

№	Зүйл, заалт	Эрүүгийн хуулийн зүйл, заалтын гарчиг
1.	10.1	Хүнийг алах
2.	11.1	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах
3.	11.4	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах
4.	12.1	Хүчиндэх
5.	12.3	Бэлгийн мөлжлөг
6.	13.1	Хүн худалдаалах
7.	13.2	Хүн хулгайлах
8.	13.3	Хүн барьцаалах
9.	13.4	Хүнийг хүчээр алга болгох
10.	15.3	Хүний цус, эс, эд эрхтнийг хууль бусаар авах
11.	15.5	Хууль бусаар үр хөндөх
12.	16.1	Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах
13.	16.3	Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх
14.	16.6	Хүүхэд худалдах
15.	16.7	Хүүхэдтэй хэрцгий харьцах
16.	16.11	Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх
17.	17.2	Дээрэмдэх
18.	19.3	Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах
19.	21.12	Эрүү шүүлт тулгах
20.	29.1	Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх
21.	29.8	Террорист үйлдэл хийх

Журамд “Хүн худалдаалах гэмт хэргийн зүйл ангийг” нэмж оруулснаар энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид учирсан хохирол, нөхөн төлбөрийг олгох эрх зүйн орчин бүрдсэн. Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглох, нөхөн төлбөр олгоход шаардагдах хөрөнгийг дараа жилийн төсөвт тусгуулах, сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын тайлан, бүртгэл тооцоог шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж буй гүйцэтгэх баримт бичгийг үндэслэн хөтөлж, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй тайлагнахаар тус тус зохицуулсан байдаг.

Гэвч Эрүүгийн хуулийн 13.1 зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэргийн хэдэн хохирогчид дээрх сангаас хэдэн төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь тодорхойгүй байна.¹⁹

Энэ сангаас Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйл “Бэлгийн мөлжлөг”, 13.1 дүгээр зүйл “Хүн худалдаалах”, 15.3 дугаар зүйл “Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах”, 16.6 дугаар зүйл “Хүүхэд худалдах” гэх гэмт хэргүүдийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн шийдвэрт заасан эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг нөхөн олгохоор заасан ч нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдохоор заасан. Гэвч энэ нь нотлох баримт хангалтгүй, цуглуулах боломжгүй байсан тохиолдолд хохирогчид учирсан хохирол хэдий өндөр ч нөхөн төлөгдөхгүй байх үр дагаварт хүргэж байна.²⁰

¹⁹ Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан. 2023 он.

²⁰ Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал. Азийн сан, Хүйсийн тэгш эрх төв ТББ-ын хамтарсан судалгааны багийн тайлан. 2021 он.

ДӨРӨВ. ХОХИРОГЧИД НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АЖЛЫГ ЦААШИД ХЭРХЭН САЙЖРУУЛАХ ТАЛААРХ САНАЛ

Хохирогчид учирсан их, бага хэмжээний хохирол нөхөн төлөх шийдвэр гардаг ч түүнийг олгох, барагдуулж дуусгах хугацааг холбогдох эрх зүйн актад тодорхой зааж өгөөгүйгээс хохирогч нар хэдэн жилийн турш чирэгдэн, хохирлоо авч чадахгүй, хохирсоор байгаа нь үнэн. Иймд энэ асуудлыг эрх зүйн актаар нарийвчлан зохицуулах нь хохирогчид тулгарч буй хүндрэлийг багасгах, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, хохирол, нөхөн төлбөрийг хугацаа алдахгүй олгох, цаашлаад хууль, шүүхийн байгууллагад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй байна.

“Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-гаас хохирогчид нөхөн төлбөр олгосны дараа буруутай этгээдээр нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалттай. Гэвч Засгийн газрын тусгай сангаас олгох нөхөн төлбөр, сэтгэцийн хохирол барагдуулах ажиллагааны журамд тодорхой хугацаа тавьж өгөөгүйгээс олон жилийн турш хохирол, нөхөн төлбөрөө гаргуулж авч чадаагүй иргэд олон байдаг. Хэдийгээр тэд Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч биш боловч журмын хэрэгжилтийг сайжруулах нь хохирсон бүх иргэдэд хамааралтай асуудал билээ.



Жишээ – 10

Судалгаанд оролцсон мөрдөгчийн ярианаас.

Эрүүл мэндийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 онд хамтран баталж, 2017 онд өөрчлөлт оруулсан “Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”²¹-ын 6.1 дэх хэсэгт зааснаар гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэхдээ 1. Эрүүл мэндийн тухай хуульд заасан улсын төсвөөс санхүүжих эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, 2. иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан иргэний эрүүл мэндийн даатгалаас санхүүжих тусламж, үйлчилгээ, 3. тус журмын 6.3 дахь хэсэгт заасан тусламж үйлчилгээнээс бусад зардлыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу

²¹ Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын 2014 оны 10-р сарын 24-ний өдрийн №356, А/182 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан, мөн тус журамд Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/250/А-171, Хууль зүй, дотоод хэргийн нсайдын А/250, А-171 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулсан.

санхүүжүүлэхээр заасан. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан 24 төрлийн сангуудын тусгай сан нэг нь “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан” юм. Тус сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгох зориулалттай.²² Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-с хохирогчид нөхөн төлбөр олгосны дараа буруутай этгээдээр нөхөн төлүүлэх зохицуулалттай.

Гэвч Засгийн газрын тусгай сангаас олгох нөхөн төлбөр, сэтгэцийн хохирол барагдуулах ажиллагааны журамд тодорхой хугацаа зааж өгөх шаардлагатай бөгөөд хохирол барагдуулах хугацааг тодорхой зааж өгөөгүйгээс олон жилийн турш хохирол, нөхөн төлбөрөө гаргуулж авч чадаагүй иргэд олон байна.

Мөн бэлгийн мөлжлөгтэй холбоотой хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хохирогч нарыг эмнэлэгт үзүүлэхээр очиход оочир, дараалал ихтэй байдаг тул хүнд гэмт хэргийн буюу бэлгийн мөлжлөг, хүн худалдаалахын хохирогч нарыг олны дунд суулгаж, удаан хүлээлгэмээргүй байна. Гэтэл гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг анхаараад бусад хохирогч нарыг тэд анхаардаггүй нь өрөөсгөл санагддаг.



Жишээ - 11

Судалгаанд оролцсон мөрдөгчийн ярианаас.

Бусад орны туршлагаас дурдвал Нидерланд улсад 8 сарын дотор хохирол барагдуулах, нөхөн төлбөр олгох ажиллагааг явуулж дуусгахаар заасан бөгөөд уг хугацааг өнгөрөхөд Шүүхийн шийдвэр биелүүлэх албанаас хохирогчид төлбөрийг олгон, буруутай этгээдээс дараа нь нөхөн гаргуулахаар хуульчилсан байгааг Монгол Улсад нэгэн адил нутагшуулах боломжтой гэж үзэж байна.

Цаашилбал, энэхүү төрлийн харилцаанд онцгой үүрэг бүхий өөр нэгэн журам нь 2024 оны 03-р сарын 04-ний өдөр батлагдсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам” юм. Тус журамд зааснаар хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах ажиллагаа эрүүл мэнд, боловсролын байгууллагуудад ч хамаатай бөгөөд үүнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Тодруулбал, тус журам нь хүн худалдаалах гэмт хэрэгтэй

²² Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг.

тэмцэхэд чухал ач холбогдолтой байх тул төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс уг журмыг холбогдох байгууллагуудад танилцуулах, хэрэгжилтийг хангах зэрэг ажиллагааг хийх шаардлагатай байна.

Дээрх журамд зааснаар хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг явуулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж болон энэхүү журмыг баримтлах ба хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангахад хүний эрхийг дээдлэх, хувийн нууцыг хамгаалах, үл ялгаварлан гадуурхах, төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаанд суурилан хэрэгжүүлнэ.²³

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан нь энэхүү журмыг дагаж мөрдөж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг ханган ажиллана. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн хохирогч болсон тохиолдолд хохирогчийг өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэлээрээ харилцах боломжоор хангаж, үзүүлэх хамгаалалтын арга хэмжээг түүний сайн мэдэх хэлээр, эсхүл орчуулагчийн тусламжтайгаар тайлбарлаж өгнө.²⁴

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, сэжиглэгдэж буй этгээдийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан эсэхээс үл хамаарч хүн худалдаалах гэмт хэргийн улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хохирогчоор тогтооно.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй талаарх мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллага хүлээн авсан даруйд хохирогчийг таньж тогтоох арга хэмжээг авна. Хохирогчийг таньж тогтоох ажиллагааг Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх заавар, асуулгын дагуу явуулна.²⁵

Дээрх журмын 1.3-т заасан эрх бүхий албан тушаалтан, өмгөөлөгч, хэргийн бусад оролцогч нь хохирогчийн Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуульд заасан хувийн болон эмзэг мэдээллээс гадна гэмт хэргийн хохирогч болсон тухай мэдээллийн нууцлалыг

²³ Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журмын 1.2 болон 1.3 дахь хэсэг, 2024 он., үзэх - <https://cccp.gov.mn/news/48/282>

²⁴ Мөн журмын 1.4 болон 1.5 дахь хэсэг.

²⁵ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04-р сарын 05-ны өдрийн А/57 тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх заавар, асуулга”.

хангаж ажиллана. Шүүх хуралдаанд биечлэн оролцож, мэдүүлэг өгөх боломжгүй хохирогчийг мөрдөгчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн прокурор нь шүүх хуралдаанаас өмнө дуу-дүрсний бичлэг ашиглан хохирогчоос мэдүүлэг авахыг мөрдөгчид даалгах ба шүүх хуралдаанд зайнаас /цахимаар/ оролцох боломжийг шүүх хангах үүрэг хүлээсэн.

Хохирогчийн мэдүүлгийг шүүх хуралдаанд сонсгох, шүүх хуралдаанд цахимаар оролцуулж, мэдүүлэг авах үед хохирогчийн дүр төрхийг нууцлах, дуу хоолойны өнгийг өөрчлөх зэргээр мэдээллийн нууцлалыг өндөр хэмжээнд хангах, хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг авах; шүүхийн байр руу орох, гарах гарцын аюулгүй байдлыг нягтлан шалгасан байх, тухайн хэргийг шалгаж байгаа мөрдөгч, хяналт тавьж буй прокурорыг солихгүй байх, эрсдэлийн үнэлгээ өндөр гарсан болон Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар хохирогчийг хамгаалах байранд хүргэх; Хүүхэд хохирогч болсон талаарх мэдээллийг түүний эцэг эхийг олж тогтоомогц мэдэгдэх ба хэрэв түүнийг хохироох үйлдлийг эцэг эх хийсэн бол хүүхдийг нэн даруй гэр бүлээс нь тусгаарлах, Хохирогч хүүхдийг энэ журмын 5.2 дугаар зүйлд зааснаар аюулгүй байдлыг хамгаалах ба хамгаалах байранд насанд хүрсэн хохирогчоос тусад нь байрлуулах зэрэг нарийвчилсан зохицуулалтууд уг журамд тусгагдсан байна.

ДҮГНЭЛТ

Дээрхийг нэгтгэн дүгнэхэд ХХГХ-ийн хохирогчид учирсан эдийн болон эдийн бус хохирлыг барагдуулах, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоор гэмт хэргийн хохирлыг хэрхэн нөхөн төлүүлж байгаа талаар хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагааны явцад болон шүүх ажиллагааны бүхий л явцад хохирогч, түүний гэр бүлийг мэдээллээр ханган үр дүнгийн талаарх тогтмол мэдээлэх шаардлагатай байна. Түүнчлэн шүүхийн болон захиргааны журмаар хохирол барагдуулах тохиолдолд түүний бүх эрхийг танилцуулах ба эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийн талаар мэдээлэхээс гадна тэдгээрийг ашиглах боломжоор хангах, мөн хохирогчийн өмнө төр өөрийн үүргийг биелүүлэхийн тулд тусгай зориулалтын сан байгуулах, бэхжүүлэх хэрэгтэй бөгөөд энэ нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тунхаглалд дурдагдсан заавал анхаарах ёстой асуудал юм.

Хэрэв сан нь хохирлын хэмжээг бүрэн барагдуулах боломжгүй бол энэ зориулалтаар нэмэлт сан байгуулах боломжийг ашиглаж болох

юм. Хохирол барагдуулах механизм нь хялбар, хэрэгжих боломжтой байхаас гадна шударга, зохих баримт судалгаанд үндэслэгдсэн, өртөг чирэгдэл багатай байна.

Хохирогчид учирсан хохирлыг барагдуулахаас гадна түүний гэр бүлийн гишүүн, халамжид нь байгаа бүх хүмүүс нөхөн төлбөр авах эрхтэй, хэрэг хянан шийдвэрлэх үед гарч байгаа зардлыг нь гаргуулах эрх, зэргээр хангагдах шаардлагатай гэж үзэж байна. Энэхүү баримт нь шүүх, хуулийн байгууллагын ажилтанд хохирогчийн асуудлаар зохих мэдлэг олгох, хохирогчийг хамгаалах механизмыг бүрдүүлэхэд ач холбогдолтой юм. Гэсэн хэдий ч Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас олгож буй нөхөн төлбөр нь хохирогчид учирсан хохирлыг бүрэн барагдуулж байгаа эсэх, нөхөн төлбөрийг хэдий хугацаанд олгож байгаа талаарх судалгаа мэдээлэл байхгүй байгаа нь сангийн үйл ажиллагаа учир дутагдалтай байгааг харуулж байна.

Олон улсын хамтын нийгэмлэгээс батлахыг урилсан нийт 16 эрх зүйн актуудаас Монгол Улсад дийлэнх нь хэрэгжиж Гэрч, хохирогчийг хамгаалах төрийн бодлогыг боловсруулж, холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлсэн журам, заавар, аргачлал, стандарт болон гэрч хохирогчтой ажиллах дүрмийг боловсруулаад мөрдөж байна.

Харин хохирогчид туслалцаа үзүүлэх алба нэгж байгуулах, хохирогчид туслалцаа үзүүлэхэд шаардлагатай хөрөнгө зарцуулах механизм бүрдүүлэх, хохирол барагдуулах боломжийн талаар мэдээллийг ил болгох, хохирогч нарыг мэдээллээр хангах, хохирол барагдуулах асуудлыг шийдвэрлэсний дараа гэмт этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх зэрэг асуудалд анхаарлаа хандуулж, ажил хэрэг болгох хэрэгтэй байна.

Цаашид хохирогчийн хохирол, нөхөн төлбөрийг олгож, бүрэн хохиролгүй болгоход дараах асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

Нэг. Хохирогчид учирсан хохирлыг барагдуулах үүднээс гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, олсон орлогыг олж тогтоох, хураах, битүүмжлэх ажиллагааны явц, үр дүнгийн хувьд:

- Эрүүгийн хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шилжүүлэх, шийдвэрлэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорын хамтарсан захирамж, тушаалаар баталсан

журмыг баримталж, хэргийн ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлж, гэрэл зургийн үзүүлэлт үйлдэн, үзлэгийн тэмдэглэлд хавсаргадаг. Харин шаардлагатай тохиолдолд дуу-дүрсний бичлэг хийн, цахим хэрэгсэлд хуулбарлан авах ба хураан авсан эд зүйлийг нотлох баримтын ач холбогдолтой гэж үзвэл эд мөрийн баримтаар тооцох тухай тогтоол үйлдэж, хавтаст хэрэгт хавсаргах журмын хэрэгжилтийг хангах шаардлагатай байна.

Хоёр. Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй ажиллагааны шат бүрд хохирол барагдуулах ажиллагаа хэрхэн явагдаж байгааг судлан тодорхойлж, дүгнэлт гаргах ажлын хүрээнд:

- Учирсан хохирол, нөхөн төлбөрийн талаар хэрхэн мэдүүлэг авах, авсан мэдүүлгээ хэрхэн баримтжуулах, нотлох баримт бүрдүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас олсон орлого, эд хөрөнгийг тодруулан шалгах, битүүмжлэх, хураах, шинжээч томилох, үнэлгээ тогтоох, тэдгээрийг хохирогчийн хохирлыг нөхөн төлөхөд чиглүүлэх зэргээр холбогдогчийн бусдад учруулсан хохирол төлбөрөө сайн дураар төлөх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.
- Гэмт хэргийн улмаас олсон орлого, эд хөрөнгийг төлбөрт тооцох, хохирол төлбөрийг гаргуулах зэргээр хохирогчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажиллагааны заавар, зөвлөмжийг тодорхой давтамжтайгаар мөрдөгч болон холбогдох бусад ажилтнуудад өгөх шаардлагатай байна.

Гурав. Хохирол барагдуулах, нөхөн олговор олгохоор шийдвэрлэсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг судлан, хэлбэрүүдийг тогтоох ажлын хүрээнд:

- Хохирогч өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх боломжийг бүрэн хуульчилсан байгаа ч түүнд хохирол төлбөрөө нэхэмжлэх, шаардах эрхийг нь тайлбарлах, холбогдох мэдээлэл өгөхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.
- ХХГХ-ийн хохирогчид хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр олгохоор заасан нөхөн олговрыг холбогдогч сайн дураар биелүүлсэн эсэх, эсхүл албадан гаргуулсан эсэх болон хохирол барагдуулах, нөхөн олговор олгох ажиллагаа ямар хугацаанд үргэлжилж байгаа талаарх судалгааг Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх байгууллагын тоон мэдээлэл болон албан хаагчидтай хамтран жил бүр боловсруулах, түүнд үндэслэн энэхүү ажиллагааг сайжруулах санал зөвлөмжийг практикт үндэслэлд тулгуурлан боловсруулах;

Дөрөв. Хохирогчид нөхөн олговор олгох ажлыг цаашид хэрхэн сайжруулах талаар санал:

- ХХГХ-ийн хохирогчийн нөмгөөлөгчийн үүрэг, оролцоог сайжруулах, түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, улсын яллагч, эсхүл шүүхийн зүгээс хохирогчийн өмгөөлөгчид шүүх хурлын товыг заавал мэдэгдэж, шүүх хуралдаанд оролцон хохирогчийн эрхийг хамгаалах, мэтгэлцэх боломжоор хангуулахад анхаарах хэрэгтэй байна.
- Хохирогчид учирсан хохирлыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад барагдуулах нь хохирогчийн цаг хугацааг хэмнэх, эдийн засгийн хэмнэлттэй байдаг тул дараа нь нотлох баримт бүрдүүлэн Иргэний хэргийн шүүхээр хохирол хор уршгийн нөхөн төлүүлэх шийдвэр гаргалгүйгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад, эрүүгийн хэргийн тогтоолын дагуу хохирлын асуудлыг нэг мөр шийдвэрлүүлэхийг эрхэмлэх шаардлагатай байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ирсэн бүх л гүйцэтгэх хуудасны дагуу шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгддэг боловч насанд хүрээгүй хохирогчтой холбоотой хохирол барагдуулах ажиллагаанд онцгой анхаарч, цаашид насанд хүрээгүй төлбөр авагчтай холбоотой шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тусгайлсан эрх зүйн орчныг бий болгох, мөн энэ чиглэлээр тодорхой тооны шийдвэр гүйцэтгэгчийг мэргэшүүлэн ажиллуулах зайлшгүй хэрэгцээ байна.
- Хохирол нөхөн төлөх шийдвэр гарсан боловч хохирогч нар хохирлоо авч чадахгүй, олон сар жилийн турш чирэгдэн хохирч байгаад анхаарлаа хандуулж, холбогдогчийг тодорхой хугацааны дотор бусдад учруулсан хохирол төлбөрөө бүрэн төлж барагдуулахыг үүрэг болгосон хугацаа тогтоох нь чухал ач холбогдолтой байна.
- “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”-д заасан хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах ажиллагаа эрүүл мэнд, боловсролын

байгууллагуудад ч хамаатай тул энэ төрлийн байгууллагуудтай энэ чиглэлийн асуудал хариуцсан төрийн эрх бүхий байгууллага, төрийн бус байгууллагууд хамтран ажиллан ХХГХ-ийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, хохирогчийн эмзэг байдлыг харгалзан үзэх шаардлагатайг ойлгуулах нь чухал юм.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Хохирогчийн эрхийг хамгаалах эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт тусгалаа олсон "... хүн бүр өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх" бөгөөд энэхүү Үндсэн хуулиар баталгаажсан суурь эрхийг хангах үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг заасан процессын хуулиудын нэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль юм.

ЭХХШТХ-д зааснаар ХХГХ-ийн хохирогчийн өмгөөлөгч нар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эхнээс нь оролцох эрхтэй боловч ажиллагааны дарааллын хувьд энэхүү эрх бүрэн хэрэгждэггүй буюу өмгөөлөгч хавтаст хэрэгтэй танилцсаны дараа хохирогчийн эрхийг хамгаалах зорилгоор аливаа санал, хүсэлт гаргах эрхтэй байгаа учир дутагдалтай байна. Улмаар хавтаст хэрэгтэй танилцах үед хэргийн дийлэнх ажиллагааг хийгдсэн байх тохиолдол цөөнгүй бөгөөд үүний дараа өмгөөлөгчийн гаргах хүсэлтийг мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, цаашлаад шүүхийн шатанд шүүгчид хангадаггүй асуудал байсаар байна. Зарим тохиолдолд хүсэлт, гомдлыг хүлээн авдаггүй мөрдөгчид байдаг талаар өмгөөлөгчид судалгааны явцад цохон тэмдэглэж байв. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өмгөөлөгчийн оролцоог сайжруулах, тэдний хуульд заасны дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээг явуулах боломжоор мөрдөгч, прокурор, эрх бүхий албан тушаалтан болон шүүх тухай бүр хангах хэрэгтэй байна. Нөгөөтэйгөөр өмгөөлөгчийг өөрийн ажилд хариуцлагатай хандах, өөрийн үүргийг сайтар ухамсарлах талаар Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбоо зэрэг холбогдох мэргэжлийн байгууллага болон ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд өмгөөлөгч нартай хамтран ажиллаж тэдний хариуцлагыг сайжруулах нь зүйтэй.

Цаашид ХХГХ гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан уналга, эд зүйл, галт зэвсэг зэргийг хэрхэн олж тогтоох, тэдгээрийг битүүмжлэн хураах ажиллагаа, тухайн эд хөрөнгөөр хохирогч нарын нөхөн төлбөрийг барагдуулах ажлыг сайжруулах, өмгөөлөгчийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор дараах саналыг гаргаж байна. Үүнд:

Нэг. ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт заасан “Өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх, өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой баримтыг нотлох баримтаар тооцохгүй” гэсэн нь дараах байдлаар өрөөсгөл ойлгогдож байна. Тодруулбал:

- “ Өмгөөлөгчтэй байгуулсан “Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ” нь эрүүгийн хэргийг нотлох нотолгооны баримт биш гэж үзэж болох боловч өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой буюу ХЗТ-аа авахдаа төлбөр төлсөн баримт нь хохирогчид учирсан хохирлыг нотлох, учирсан хохирлын бодит хэмжээг тогтооход чухал учраас нотлох баримтаар тооцохгүй байх үндэслэлгүй. Хууль зүйн туслалцааны төлбөрийн хэмжээ нь удаан хугацаанд шалгагдсан, эсхүл олон өмгөөлөгч сольж ажиллуулсан хэрэг дээр нэмэгдсэн байж болох учир нотолгооны нэг баримт болох учиртай. ЭХХШТХ-ийг боловсруулахдаа гэмт хэрэг болон гэм бурууг нотлох талаар голлон анхаарсан байх тул дээрх хуулийн заалтад Хууль зүйн туслалцаа үзүүлсэнтэй холбоотой санхүүгийн болон бусад баримт нь нотлох баримтын нэг хэсэг болох байдлаар өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

Хоёр. ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг “...Хохирогч, яллагдагч тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурор авч хавтаст хэрэгт тусгаж хавсаргана” гэх зохицуулалтын хэрэгжилт практикт хүндрэлтэй байна. Тодруулбал, ХХГХ-т бус өөр гэмт хэрэгт ч эд зүйл, баримт бичиг, гомдол мэдээлэл, санал, хүсэлтээ өгөхөд тухайн өргөдөл хүсэлтийн хариуг өгөх нэмэлт ажиллагаа хийх ажил мөрдөгчид гардаг тул тэд ачааллаа нэмэхгүй байх үүднээс хэрэгт хавсаргахгүй байх тохиолдол гардаг. Иймд энэ төрлийн ажиллагааны практик хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 16.1.10 дахь хэсгийн хэрэгжилтийн талаар тухайлсан судалгааг мөрдөгч нарын дунд явуулж, түүнийг сайжруулах зөвлөмжийг хүргүүлэх, энэ чиглэлийн сургалтыг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

Гурав.ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 14 дэх хэсэгт заасан “Нотлох баримтыг шинжлэн судлах явцад хэрэгт ач холбогдолтой, хамааралтай эсэхэд эргэлзэх үндэслэл байвал тухайн нотлох баримтыг шүүх, прокурорын шийдвэрийн үндэслэл болгохгүй” гэх заалтын “эргэлзэх үндэслэл” гэдэг юуг, хэрхэн ойлгох талаар тодорхой тайлбар байхгүй байгаа нь прокурор болон шүүх нотлох баримтыг өөрийн үзэмжээр үнэлэхгүй байх сөрөг үр дагаврыг бий болгож байна: Тодруулбал “эргэлзэх үндэслэл” гэдэгт:

- хуулийн шаардлага хангаагүй баримтыг ойлгох эсэх;
- эх сурвалж тодорхойгүй баримтыг ойлгох эсэх;
- ЭХХШТХ-д заасан журмын дагуу бүрдүүлээгүй нотлох баримтыг ойлгох эсэх нь тодорхойгүй тул энэхүү ерөнхий ойлголтын хүрээнд тухайн прокурор, шүүгч, шүүх бүрэлдэхүүнд субъектив буюу өөрийн үзэмжээр дүгнэлт хийх боломжийг бий болгож байна.

Иймээс хохирогчийн хохирол, нөхөн төлбөртэй холбоотой баримт эргэлзээтэй байвал хохирлын нэхэмжлэл хангагдахгүй байх нөхцөл бүрдэх учир хохирогчид “нотлох баримтын шаардлага хангасан байх” гэсэн үндэслэлд юу хамаарахыг тодорхой хэлж, зөвлөх, холбогдох мэдээллийг цаг алдалгүй өгч, нотлох баримтыг зөв бүрдүүлэх зайлшгүй шаардлага үүсчээ. Хохирогчид өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх боломжтой хэдий ч хохирол, төлбөр гаргуулах тухай эрхийг нь мөрдөгч, прокурор, өмгөөлөгч нар хохирогчид тодорхой тайлбарлаж өгөх асуудал хангалтгүй байгаагаас хохирол, нөхөн төлбөрөө нэхэмжилж чадахгүй байгаа нь харагдаж байна.

Дөрөв.ЭХХШТХ-ийн 16.7 дугаар зүйлийн 2 дахь заалтад “Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нөхцөл байдал нь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээс зөрсөн тохиолдолд шүүх, прокурор дууны, дүүрсний, дуу-дүрсний бичлэгийг нотлох баримтаар тооцоно” гэж заасан. Гэтэл хэргийг шүүхээр хэлэлцэх явцад МША-ны үед хийсэн зарим ажиллагааг хохирогч, холбогдогч нар хүлээн зөвшөөрөхгүй байх явдал шүүх хурал дээр ажиглагддаг. Энэ тохиолдолд шүүх дууны, дүүрсний бичлэгээс илүүтэйгээр хохирогчийн болон бусад оролцогчийн мэдүүлгийг үндэслэн хэргийг шийдвэрлэдэг жишиг тогтоожээ. Зүй дууны, дүрсний болон дуу-дүрсний бичлэгт үндэслэх ёстой боловч ийнхүү хуульд заасны дагуу баталгаажуулсан баримтыг хавтаст хэрэгтэй хамт ирүүлдэггүй нь ЭХХШТХ-ийн 16.7.2 дахь хэсэг

практикт хэрэгжилтийг удаашруулж байгаа тул үүнийг анхаарч, хэргийн материалын хамт дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг ирүүлэх шаардлагатайг харуулж байна.

Тав. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох засгийн газрын тусгай сангаас гадна Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай тусгай санг бүрдүүлж, түүнтэй холбоотой эрх зүйн орчныг бий болгох шаардлага үүсжээ. Мөн Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас олгох нөхөн төлбөр, сэтгэцийн хохирол барагдуулах ажиллагааны журамд тодорхой хугацаа зааж өгөх шаардлагатай байна.

Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журамд хохирол барагдуулах хугацааг нарийвчлан зааж өгөөгүйгээс өнөөдрийг хүртэл олон жилийн турш хохирлоо гаргуулж авч чадаагүй иргэд олон байна. Бусад орны туршлагаас харвал зарим улсад 8 сарын дотор шийдвэрлэх хугацаа заадаг байдаг.

Зургаа. Шүүх хуралдаанд ХХГХ-ийн хохирогчийн өмгөөлөгчийг заавал оролцуулах талаар прокуророос шүүхэд санал оруулах, эсхүл яллах дүгнэлтэд тодорхой тусгах хэрэгтэй байна. Хэргийг олон удаа буцаах, улмаар шийдвэрлүүлэх болоход хэдийд шүүхэд ирсэн, шүүх хурал хэдийд товлогдсон талаар хохирогчийн өмгөөлөгч нарт мэдээлэхгүй тохиолдол гарсаар байна. Зарим шүүх хохирогч руу утсаар холбогдон *“чи ирээд хэрэггүй байх”* гэхээр хохирогч нь *“би очихгүй юм чинь өмгөөлөгч бас хэрэггүй байх”* гэж хэлсэн тохиолдол гарсан тухай мэдээлэл байна. Иймд улсын яллагч эсхүл шүүхийн зүгээс хохирогчийн өмгөөлөгчид шүүх хурлын товыг заавал мэдэгдэж, шүүх хуралдаанд хохирогчийн эрхийг хамгаалах ажиллагааг тухайн бүр хийх нь зүйтэй байна.

Хохирогчийн мэдлэггүй, өөртөө итгэлгүй, төлбөрийн асуудлаас болж гомдол санал гаргадаггүй байдлыг өөрчилж, хохирол, нөхөн төлбөрөө гаргуулахтай холбоотой мэдээлэл өгөх ажиллагаанд мөрдөгч, прокурор, өмгөөлөгч нар идэвхтэй оролцох шаардлагатай байна.

Долоо. ХХГХ-ийн хохирогчид учирсан хохирол, төлбөрийг барагдуулахтай холбоотойгоор мөрдөгч ямар ажиллагаа хийсэн, прокурор түүнд ямар хяналт хэрэгжүүлсэн талаар яллах дүгнэлтийн хавсралтад дэлгэрэнгүй оруулах нь энэ төрлийн ажиллагааг хэрэг

бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад эрчимжүүлэхэд онцгой ач холбогдолтой. Мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан ажиллагааны тэмдэглэлд ихэвчлэн яллагдагч “төлөх төлбөргүй” гэж бичдэг боловч хэдийд ямар ажиллагаа хийсэн нь тодорхойгүй байдаг. Мөн анхан шүүхээс мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирол барагдуулах ажиллагаанд анхаарч, хэрэгт холбогдогчийн нэр дээрх хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг бүртгэж, битүүмжлэх ажиллагаа хийгдсэн эсэх талаарх мэдээллийг прокуророос шаардах нь хохирлыг даруй барагдуулах, хохирогчийн сэтгэл зүйл эерэг нөлөө үзүүлэх, цаашлаад хэргийг нэг мөр шийдвэрлэх, дахин иргэний хэргийн шүүхэд хандахгүйгээр хохирогчийн цаг, мөнгийг хэмнэх, сэтгэл зүйн хувьд хурдан эдгэхэд онцгой ач холбогдолтой болох нь судалгааны явцад илэрхий болсон.

Найм. Улсын яллагч шүүх хуралдаанд оролцохдоо ХХГХ-ийн хохирогчид учирсан хохирол төлбөрийг гаргуулах баримтад анхаарах хандуулах талаар:

- Яллах дүгнэлтэд “хохиролгүй, төлөх төлбөргүй” гэх атлаа “Иргэний журмаар баримтаа бүрдүүлж хохирлоо гаргуулах боломжтой” гэсэн 2 агуулга нь зөрчилдөж байгааг өөрчлөх. Энэхүү зөрчилдөөнтэй дүгнэлтийн улмаас яллагдагчид шүүхээс оноосон ялыг хугацаанаас өмнө дуусгавар болох, эсхүл зохих хэмжээгээр хасуулах зэрэг боломжийг яллагдагчид бий болгох боломж бүрдэж байна.
- ЭХХША-ны бүх шатанд оролцогч хохирогч, мөрдөгч, прокурор, өмгөөлөгч нарт зориулсан Хохирол, нөхөн төлбөрийг гаргуулахтай холбоотой мэдээлэл, санамжийг Прокурорын байгууллагаас гаргах гаргах.
- ЭХХША-ны хохирол төлбөр барагдуулахтай холбоотой заалтуудыг дэлгэрэнгүй тайлбарлаж өгөх ажилд хуульч, өмгөөлөгчид болон ТББ- ууд идэвхтэй оролцох боломжтой учир тэднийг татан оролцуулах.
- Энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн талаарх бүртгэлийн механизмыг дэлгэрүүлэн сайжруулж, зарим тохиолдолд нээлттэй мэдээлэлд нэвтрэн орох эрхтэй субъектуудыг батлан хуульчлах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БҮЙ ШҮҮХИЙН ПРАКТИКТ ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2.1. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн, хуулийн хүчин төгөлдөр болсон 2021, 2022, 2023 оны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, тус гэмт хэргийн хохирогчид өөрт учирсан хохирол, хор уршгийн талаар ямар мэдүүлэг өгч байсан, учирсан хохирол, хор уршгийг тогтоох талаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулсан, хохирогчийн хохирол, хор уршгийг арилгах талаар өмгөөлөгчид хийсэн, мөн насанд хүрээгүй хохирогчдын хууль ёсны төлөөлөгчид ямар ажиллагаа явуулсан, ямар хүсэлттэй байсан, шүүх хохирогчийн хохирол хор уршгийг хэрхэн хянан шийдвэрлэсэн талаар судаллаа.

Энэхүү судалгаагаар дараах үндсэн асуудлыг тодруулахыг зорив. Үүнд:


- ХХГХ-ийн хохирогчид ямар төрлийн хохирлууд учирч болох;
- хохирол-хор уршгийг нь тогтоосноор ямар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан ямар ажиллагааг түлхүү явуулах нь илүү үр дүнтэй байх;
- хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мөрдөн шалгах ямар ажиллагааг хийлгэх шаардлагатай талаар;
- дээрхэд үндэслэн хохирогчид учирсан хохирлыг шүүхээр шийдвэрлүүлэх эрх зүйн боломжуудыг Монгол Улсад хэрэглэж буй хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэхэд тулгамдаж буй хүндрэл болон түүнтэй холбоотой хууль хэрэглээний дүгнэлтүүдийг энэхүү тайлангаар гаргахыг хичээлээ.

Энэхүү судалгаан дээр үндэслэсэн дүгнэлтүүд зөвхөн тус хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нараас гадна бусад гэмт

хэргийн хохирогчийн эрх ашгийг хамгаалах, хохирол, хор уршгийг шийдвэрлэхэд ахиц авчрах, сайжруулах болно гэж найдаж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд “Хүн худалдаалах” гэмт хэргийн зүйлчлэлээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тухайд 2021 онд 20 шүүгдэгчид холбогдох 9 хэрэг, 2022 онд 8 шүүгдэгчид холбогдох 5 хэрэг, 2023 онд 9 шүүгдэгчид холбогдох 3 хэргийг шүүх хянан шийдвэрлэжээ.

Хүснэгт – 9, 10. 2021-2023 онд Шүүхээр хянан шийдвэрлэгдсэн нийт гэмт хэрэг, ХХГХ-ийн болон шүүгдэгчийн тоон мэдээлэл.



2.2. ХХГХ-ийн хохирогчид учирсан хохирлын тухай

Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “...гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно.” хэмээн тус тус хуульчилсан. Харин ХХГХ-ийн хохирогч нэг дор олон гэмт хэргийн хохирогч болдгоороо бусад гэмт хэргээс ялгагддаг төдийгүй үүний уршгаар томоохон хор уршгууд бий болох эрсдэлтэй.

Хохирогч И.Э “...Тухайн өдөр М-нд очоод байж байтал М надад “ажил хийх үү, мөнгө олох уу” гэж хэлсэн. Би М-д “тэгье мөнгө олъё, ямар ажил юм бэ” гэж асуухад М надад яг ямар ажил хийхээ хэлээгүй. Шар өнгийн зочид буудал руу дагуулж ороход, 27 орчим настай, эрэгтэй хүн ганцаараа, хувцастайгаа, ширээн дээгүүрээ цөөхөн хэдэн лаазтай пиво тавьчихсан сууж байсан. М намайг “чи угаалгын өрөөнд ороод сууж бай” гэж хэлсэн, удалгүй М дээгүүрээ цамцаа өмсчихсөн, дотуур хувцастайгаа бие засах өрөөнд орж ирснээ “энэ хүнтэй гялс уулзчихаач, чамд мөнгө төгрөг хэрэгтэй байгаа биз дээ, жирэмсэн байгаа биз дээ, эм, лаа авах мөнгө авах хэрэгтэй байгаа биз дээ” гэж хэлсэн. Тухайн үед би 4-5 сартай жирэмсэн, тонус өгөөд ураг доошлоод, мөнгөний хэрэгцээ байсан учраас ятгалгад нь автаад М-г угаалгын өрөөнд үлдээгээд би өрөөнөөс гарч уг эрэгтэй хүнтэй 1 удаа хурьцал үйлдсэн. Буцах замдаа М-тай эмийн сан ороод эм, лаа

30.000 төгрөг орчмоор авхуулсан, өөр мөнгө аваагүй. М надад нэг гэрт адилхан идэж ууж амьдарч байж сүртэй юмаа, мөнгө олох хэрэгтэй гээд байсан. Гэнэт хүүхдээ дутуу төрүүлсэн. Намайг М, Н хоёр О гэх охиных руу авч очоод “хэл сураггүй алга боллоо чамайг эмнэлэгт байхад хэн эргэж очиж байсан билээ” гээд зодсон. Намайг зодох үед Н хөлөө үнсүүлэх гээд харин М намайг цээж болон бусад газар руу цохиж, зодож, өшиглөж зодож байсан. Миний нүүр ам хөндүүр байхад М намайг “гараад 1 хүнтэй уулзаж хурьцал үйлдээд мөнгө олоод өг” гээд 30 орчим насны эрэгтэй хүнтэй хурьцал үйлдүүлж 100.000 төгрөг авсан. ... М намайг жирэмсэн, эмзэг байсан үед миний биеийг үнэлж, дараа нь зодож биеийг минь

үнэлүүлсэнд гомдолтой, нэхэмжлэх зүйл байхгүй” гэж мэдүүлжээ.

Шүүхийн шийдвэр: -Хохирогч И.Э нь нэхэмжлэх зүйл байхгүй гэсэн байх тул шүүгдэгч Б.М, Б.М нар бусдад төлөх төлбөргүй байна гэж шийдвэрлэжээ.



Жишээ – 12

Эрүүгийн хуулийн тусгай ангид “Хүний эрүүл мэндэд учирсан хохирлыг хөнгөн, хүндэвтэр, хүнд, ноцтой” гэж гэмт хэргийн шинжийг заасан байхад ХХГХ-ийн хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирлыг дан ганц бие махбодод учирсан гэмтлийн зэргээр хязгаарлаж байна. Дээрх тохиолдлын тухайд хохирогч нь бие давхар байсан, мөн гэмтлийн зэргээр тогтоогдохгүй гэмтэл удаа дараа авч байснаас үүдэн сэтгэл санааны хувьд хүнд шархтай болсон хэдий ч прокурор, цаашлаад шүүхээс шүүгдэгч нарыг бусдад төлөх аливаа төлбөргүй гэж үзсэн нь практик энэ төрлийн харилцаанд илүү нарийвчилсан зохицуулалт шаардлагатайг илтгэж байна.

ХХГХ-ийн хохирогч нь гэмт хэргийн явцад бэлгийн замын болон бусад төрлийн өвчтэй болсон тохиолдолд элбэг байна. Дүн шинжилгээ хийсэн эрүүгийн хэргүүдийн нийт 49 хохирогчоос 16 хохирогч өвчлөлтэй болсон байна.

Хүснэгт 11.ХХГХ-ийн улмаас бий болсон өвчлөлийн мэдээлэл.

ХӨНГӨН ГЭМТЭЛ ТОГТООГДСОН	БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ БОЛСОН	ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ӨВЧИНТЭЙ БОЛСОН	ГЭМТЭЛ УЧИРЧ БАЙСАН НЬ ТОГТООГДСОН	ЖИРЭМСЛЭЭД ТӨРҮҮЛСЭН	ЖИРЭМСЭЛЖ БАЙСАН
1	5	1	3	1	5
НИЙТ ХОХИРОГЧ			49		

ХХГХ-ийн тохиолдол бүрд хохирогчийн эрүүл мэндэд нь ямар өөрчлөлтүүд гарсан талаар тодорхой мэдүүлэг авч, тэрхүү мэдүүлэгт дурдагдсан шинж тэмдгүүд нь гэмт хэргийн хохирогч болсон цаг үеэс бий болсон байж болох нөхцөл байдлуудтай нь холбоотой эрүүл мэндийн гэмтлийг нь тогтоох ажиллагааг ХХГХ-ийн хохирогч бүрд бүрэн хийдэггүй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмтлийн зэрэг тогтоох эрх бүхий байгууллага 2024 оныг хүртэл 2014 онд батлагдсан “Гэмтлийн зэрэг тогтоох журам”²⁶-ыг баримтлан бие махбодод бий болсон гэмтлийг тогтоож байсан бол 2024 оны 05 дугаар сараас эхлэн “Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журам”²⁷-ыг үндэслэн хохирогчийн биеийн анатоми, физиологид учирсан гэмтлийг л тогтоож байна. Ийнхүү зөвхөн бие махбодод учирсан гэмтлээр Хохирогчийн эрүүл мэндэд учирсан гэмтлийн хэр хэмжээг тогтоож байгаа нь учир дутагдалтай юм.

Тухайлбал, судалгаа хийсэн 49 хохирогчийн биед учирсан гэмтэл дээр гэмтлийн зэрэг тогтоолгох шинжээчийн дүгнэлтийг гаргуулж, гэмтэл тогтоогдвол энэхүү бие махбодод учирсан гэмтлээр нь эрүүл мэндэд нь хөнгөн, хүндэвтэр зэргийн гэмтэл учирсан гэж шийдвэрлэжээ.

²⁶ Монгол Улсын Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12-р сарын 05-ны өдрийн хамтарсан А/216/422 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан.

²⁷ Монгол Улсын Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2024 оны 05-р сарын 21-ний өдрийн хамтарсан А/225/А/153/А/85 тушаалын хавсралтаар батлагдсан.

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад хүний "...эрүүл мэнд" гэж хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг;..." хэлнэ гэж заасан. Энэхүү тодорхойлолт нь:

1. биед учирсан өвчин эмгэггүй,
2. оюун санааны гэмтэлгүй,
3. амьдралын хувьд сайн сайхан байх гэсэн өргөн ойлголтыг хамруулсан байхад практикт дан ганц бие махбодод учирсан гэмтлийн зэргээр хохирогчийн эрүүл мэндэд учирсан гэмтлийг хязгаарлаж байгааг өөрчлөх цаг нь болжээ.

ХХГХ-ийн 49 хохирогчийн энэ гэмт хэргийн улмаас ямар нэг өвчинтэй болж үлдсэн эсэх, оюун санаа нь гэмтсэн эсэх, амьдралын сайн сайхан байдал нь ямар хэмжээгээр алдагдсан болохыг тогтоогоогүй, энэ талаар тусгай мэдлэг бүхий шинжээчээр тогтоолгох ажиллагааг дутуу явуулжээ.

2.1.1. Хүний биед учирсан өвчин, эмгэгийг тогтоож буй практик

Өвчнийг халдварт ба халдварт бус өвчин гэж 2 ангилдаг байна.

ХХГХ-ийн хохирогчийн хувьд тэмбүү, трихомонад, заг хүйтэн зэрэг бэлгийн замын халдварт өвчнөөр өвчилсөн болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоосон байх боловч эрүүл мэндэд нь учирсан гэмтэл гэж үзэх эсэх талаар ажиллагаа хийгдээгүй байна. Энэхүү өвчлөлийг Эрүүл мэндийн тухай хуулиар хүний эрүүл мэнд гэмтсэн гэж үзэж болохоор байна.

Мөн хохирогчийн бие махбодод ил харагдахуйц гэмтэл байхгүй байж болох ч тэдний биед ХХГХ гэмт хэрэг үйлдэгчид хүчирхийлүүлснээс үлдсэн ул мөр байдаг болох нь дүн шинжилгээ хийсэн 17 гэмт хэргийн 49 хохирогчийн 3 хохирогчийн биед хийсэн "гэмтлийн зэрэг тогтоогдохгүй гадны хүчний үйлчлэлээр үүссэн гэмтлүүд" байгаа талаар шинжээчийн дүгнэлтээр нотлогдсон байв. Энэ нь хохирогчийн хүч хэрэглэж худалдаалж байсан мэдүүлгийн эх сурвалж болно.

2.1.2. Хүний оюун санааны гэмтлийг тогтоож буй практик

Оюун санааг хүний оюун ухаан, оюуны чадамжийн цогц гэж тодорхойлж болно. Хүний оюун ухааны нь ойлголт, санах ой, сэтгэхүй

гэх мэт сэтгэцийн танин мэдэхүйн үйл явцыг хамардаг.²⁸ Мөн Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад "...сэтгэцийн эрүүл мэнд" гэж хүн сэтгэцийн эмгэггүй байхын зэрэгцээ нийгэм болон хүрээлэн байгаа гадаад орчинтойгоо дасан зохицож хэвийн амьдрах, ажиллах, суралцах, нийгэмд зохих байр сууриа эзлэн хувь нэмрээ оруулж чадахуйц байдлыг" ойлгохоор хуульчилсан.

Хохирогчийн сэтгэцийн гэмтлийг тогтоогоод орхих биш, сэтгэцийн эрүүл мэнд нь хүний эрүүл мэндийн салшгүй хэсэг мөн тул сэтгэцийн гэмтлийн зэрэглэлийг /хөнгөн, хүндэвтэр, хүнд/ бие махбодод учирсан гэмтлийн зэрэгтэй адил тодорхой шалгуур бүхий зэрэглэсэн эрх зүйн акттай болох шаардлага зүй ёсоор бий болсон. Улмаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07-р сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар "Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам"²⁹-ыг баталсан.

Тус журамд зааснаар сэтгэцэд учирсан гэм хорыг

1.гэмтлээс үүдэлтэй үлдэц, 2.танин мэдэхгүй, 3.нийгмийн харилцаа, 4.төрх үйл, 5.сэтгэл хөдлөл, 6.биеийн талаас гэсэн үндсэн зургаан шалгуур үзүүлэлтийг харгалзан 1-5 дугаар түвшний зэрэглэлээр авч үзэхээр заасан. Судалгааны хүрээнд авч үзсэн 49 хохирогчийн тухайд энэхүү журмын хүрээнд сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийн тогтоох үйл ажиллагаа хараахан явагдаагүй байна.

2.1.3. ХХГХ-ийн хохирогчийн амьдралын чанарын тухай

Аливаа хүний амьдралын чанарыг хэрхэн ойлгох нь хэдий тухайн хувь хүний дотоод үнэлэмжээр тодорхойлогдох ойлголт хэдий ч ХХГХ-ийн хохирогч болсон нь тухайн хохирогчийн амьдралын чанарт хэрхэн нөлөөлсөн, нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг бий болгосон зэргийг тогтоох ажиллагааг хийх бүрэн боломжтой юм.

Тухайлбал, судалгаанд дурдагдаж буй ХХГХ-ийн 49 хохирогчийн 5 нь энэ гэмт хэргийн үргэлжлэх хугацаанд жирэмсэлсэн, үүнээс 1 хохирогч хүүхдээ төрүүлсэн байна. Эдгээр хохирогчийн амьдралын сайн сайхан байдал нь ямар байгаа болон амьдралын чанарт тус гэмт хэрэг нь нөлөөлсөн тухай тогтоосонгүй. Мөн энэ талаар дүн шинжилгээ болон

²⁸ <https://www.cognifit.com/mn/mind>

²⁹ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07-р сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар "Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам", үзэх - <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760055574281>

холбогдох бусад ажиллагаа явагдаагүй байна.

ХХГХ-ийн улмаас жирэмсэлж, хүүхэдтэй болсон эмэгтэйчүүдийн төрүүлсэн хүүхдэд ХХГХ үйлдсэн этгээдээс сар бүр хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухайлсан эрх зүйн зохицуулалтыг хуульд оруулах боломжтой юм. Хүүхдийн тэтгэмж гаргуулахтай холбоотой харилцаа нь Гэр бүлийн тухай хуулиар ерөнхий зохицуулагдсан хэдий ч ХХГХ-ийн улмаас үүссэн энэ төрлийн харилцаанд Гэр бүлийн хуулийг хэрэглэх боломж туйлын хязгаарлагдмал учир хүүхдийн нэн тэргүүний ашиг сонирхлыг төр хамгаалах, эрх зүйн баталгааг бий болгох үүднээс Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд үүнтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт тусгах шаардлагатай.

Хүүхдийн эцгээрээ тэжээн тэтгүүлэх эрх гэмт хэрэг үйлдэгчийн санаатай үйлдсэн гэмт хэргийн улмаас хохирсон гэж үзэх үндэслэлтэй тул хүүхдэд олгох тэтгэлгийн хэмжээг тухайлсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй. Иргэний хуулийн 52 дугаар бүлэгт заасан гэм хорын эрх зүйн зохицуулалтыг энэ төрлийн харилцаанд хэрэглэх нь тийм ч зохимжтой биш юм.

Гэсэн хэдий ч ХХГХ-ийн улмаас төрсөн хүүхдийн эцгээрээ тэжээн тэтгүүлэх эрхийг Иргэний хуулийн 228 дугаар зүйлийн 228.1 дэх хэсэгт “Зөрчигдсөн эрхийг сэргээх боломжгүй бол гэм хорыг мөнгөөр нөхөн төлж болно” гэж зааснаар ХХГХ үйлдэгчээс шаардаж нэхэмжлэл гарган сэргээлгэх боломжийг үгүйсгэхгүй.

Түүнчлэн өмнө дурдсан “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-аас гадна Монгол Улсын Дээд шүүхээс “Хүний сэтгэцэд учирсан хор уршгийн нөхөн төлбөрийг тооцох жишиг аргачлал”³⁰-ыг баталсан. Ийнхүү энэ төрлийн харилцаанд хохирогчийн бие махбодод учирсан гэмтлийн зэргээс гадна сэтгэцийн гэмтлийн зэрэг, түүнийг гаргуулах эрх зүйн орчныг бий болгох байдлаар сэтгэцэд учирсан гэм хорын асуудлыг зэрэг шийдвэрлэж байгаа нь Монгол Улсын эрх зүйн хөгжил мөн. Дээд шүүхээс баталсан аргачлалд нөхөн төлбөрийн хэмжээг дараах байдлаар заасан:

³⁰ 302023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 25 дугаар Монгол Улсын Дээд Шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол, үзэх - <https://nfa.gov.mn/uploads/files/Дээд%20шүүхийн%202023-07-03%2025%20дугаар%20Хүний%20сэтгэцэд%20учирсан%20хор%20уршгийг%20арилгах%20С%20нөхөн%20төлүүлэх%20төл%20өрийн%20жишиг%20аргачлалыг%20батлах%20тухай.pdf>

Сэтгэцийн эмгэгийн зэрэглэл	Сэтгэцийн хор уршиг	хувь	Нөхөн төлбөрийн хэмжээ
Хоёрдугаар зэрэглэл	Хөнгөн гэмтлийн улмаас хохирогчид үүссэн сэтгэцийн эмгэг.	4-8%	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 дахин нэмэгдүүлснээс 12,99 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл
Нэгдүгээр зэрэглэл	Биед гэмтэл учраагүй, зөвхөн сэтгэцэд үүссэн бага зэргийн эмгэг	0-3%	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4,99 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл

Дээрх байдлаар хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршигийг бие махбодод учирсан гэмтлийн зэрэгтэй уялдуулан таван зэрэглэлээр тогтоож, нөхөн төлбөр олгохоор заасан. Энэхүү аргачлалаас үзэхэд, сэтгэцэд үүссэн бага зэргийн эмгэгийн нөхөн төлбөрийг 0-3% хувь гэмтжээ гээд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4,99 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл нөхөн төлбөрийг гаргуулахаар шийдвэрлэж байна.

Сэтгэл зүйн дүгнэлт: С.М нь сэтгэцийн гэмтлийн улмаас үүссэн сэтгэл гутрал 49 оноо буюу өндөр зэрэгтэй, сэтгэл түгшилт 57 оноо буюу өндөр зэрэгтэй. Энэ нь амьдралын явцад огцом эрсдэлтэй үйл явдал тохиолдох үед үүснэ.

Үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэх: Сэтгэл зүйн гэмтэл тодорхойлох, хохирлыг үнэлэх, сэтгэл санааны хор хохирол оношилгоо, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын эмчилгээ нийт 2.800.000 төгрөг гэжээ. /хэргийн 1 дүгээр хавтас 210- 215 дахь тал/

Шүүхийн шийдвэрлэлт: Насанд хүрээгүй хохирогч С.М-д сэтгэл заслын эмчилгээ хийлгэсэн, тухайн зардал нь бодитойгоор гарсан гэх баримт хэрэгт авагдаагүй тул насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөс гаргасан нэхэмжлэлийн шаардлагаас 2.800.000 төгрөгийг хэлэлцэхгүй орхисон.³¹



Жишээ - 13

³¹ Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 95 дугаар шийтгэх тогтоол

Хохирогчийн сэтгэцэд гэмтэл учирсан байдлыг практикт ихэвчлэн мэргэжлийн шинжээчээр тогтоолгож байна. Гэхдээ сэтгэцийн гэмтлийг тооцоход тодорхой зэрэглэл бүхий эрх зүйн акт байдаггүйгээс хамгийн бага нөхөн төлбөр /нэгдүгээр зэрэглэл/ авч байна.

Гэтэл хохирогчийн бие махбодод гэмтлийн зэрэглэлд заасан гэмтэл учраагүй боловч сэтгэцийн гүн хямралд орж сэтгэцийн эдгэршгүй өвчинтэй болсон, удаан хугацаагаар эмчлэгдэх сэтгэцийн эмгэгтэй болсон бол 5,4,3,2 дугаар зэрэглэлийн алинд нь оруулах нь ойлгомжгүй буюу энэ талаар эрх зүйн зохицуулалтыг Дээд шүүхийн баталсан аргачлалд орхигдуулжээ.

Иймд батлагдсан журам, аргачлалыг практикт бодитоор хэрэгжүүлэх зорилгоор хохирогчийн сэтгэцийн эрүүл мэндийг нарийвчлан шинжлэх ур чадвар бүхий нарийн мэргэжлийн шинжээчдийг бэлтгэх, улмаар сэтгэцийн гэмтлийн зэргийг тогтоох нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох цаг үеийн шаардлага нэгэнт бий болжээ.

Мөн ХХГХ-ийн улмаас өвчинтэй болсон хохирогчийн хохирол, хор уршгийг арилгах /нөхөн сэргээх/-д шаардлагатай мөрдөн шалгах ажиллагаануудыг хийж, эмчилгээний төлбөрийн нотлох баримтын нэхэмжлэлийг хууль зүйн шаардлага хангасан байдлаар хэрэгт цуглуулж, бэхжүүлэх хэрэгтэй байна.

Энэхүү судалгаанд дурдагдаж буй ХХГХ-ийн 49 хохирогчоос 5 хохирогч нь бэлгийн замын халдварт өвчинтэй (3 хохирогч тэмбүү өвчинтэй, 2 хохирогч трихомонад өвчинтэй) болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон байхад эмчлүүлэхэд шаардлагатай зардлыг нэхэмжлээгүй, нотлох баримтуудыг хэрэгт гаргаж өгөөгүй зэргээр мөрдөн шалгах ажиллагааг явуулаагүй байна. Шүүх хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн нэхэмжлэх талаар хүсэлт гаргасан эсэхээс хамааралгүйгээр хохирогчийн жич нэхэмжлэх эрхтэй болохыг зааж шийдвэрлэдэг практик тогтжээ.

Бэлгийн замын халдварт өвчнийг эмчлүүлэхэд гарах зардлыг шийдвэрлэхүйц баримтуудыг хэрэгт оролцож буй хохирогчийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч нар гаргаж өгөх бүрэн боломжтой байсан тохиолдол мөн цөөнгүй байна.

Судалгаанд хамрагдсан 49 хохирогч нь бүгд эмзэг байдлынхаа улмаас ХХГХ-ийн хохирогч болсон байсан. Иймээс тэднээс эмчилгээний нотлох баримтаа цуглуулах, гаргаж авчрахыг шаардах боломжгүй нь илэрхий бөгөөд тэдэнд энэ талаар нэхэмжлэх хууль, эрх зүйн мэдлэг дутмаг байна. Харин хохирогч нарын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль зүйн туслалцаа үзүүлж хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчид энэ талаарх ажиллагаа явуулах хүсэлтийг мөрдөгч, прокурорт гаргах, нотлох баримтуудыг цуглуулан хэрэгт гаргаж өгч шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Хохирогчийн нэхэмжлэлийг дэмжсэн нотлох баримтуудыг хэрэгт гаргаж өгөөгүйн улмаас шүүх энэ талаар тодорхой шийдвэр гаргалгүй зөвхөн хохирогчийг энэхүү асуудлаарх нэхэмжлэлээ иргэний журмаар жич гаргах эрхтэй болохыг дурдаж шийдвэрлэж байна. Гэхдээ шүүх ийнхүү хохирогчийг өөрт учирсан хохирлоо баримтаа бүрдүүлэн тусад нэхэмжлэл гаргаж болохыг дурдах атлаа “Шүүгдэгчийг бусдад төлөх төлбөргүй” гэсэн зөрүүтэй дүгнэлтийг хийж, үндэслэлгүйгээр шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлжээ.

Хохирогч Т.А, Х.Ө, Э.С, О.Н нар нь баримтаар нэхэмжилсэн зүйлгүй байх тул шүүгдэгч О.М, Н.Т нарыг бусдад төлөх төлбөргүй болохыг дурдаж, хохирогч нар нь энэ хэргийн улмаас сэтгэл санаанд хохирол учирсан гэж үзвэл холбогдох баримтаа бүрдүүлэн Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсэг, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар иргэний журмаар нэхэмжлэх эрхийг нээлттэй үлдээх нь зүйтэй.³²



Жишээ – 14

Хохирогч өвчнөө эмчлэх, ХХГХ-ийн улмаас өөрт учирсан сэтгэл санааны хор уршгаа нотлох баримтаа бүрдүүлэн нэхэмжилбэл шүүх Иргэний хуульд заасан гэм хор учруулснаас үүсэх үүргээр хянан шийдвэрлэх эрх зүйн зохицуулалттай. Гэтэл ийм хохиролтой талаар тайлбарыг хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гаргаж байхад шүүх нотлох баримтаа бүрдүүлээд иргэний шүүхээр жич шийдвэрлүүлэх дүгнэлтийг хийсэн атлаа “шүүгдэгчийг бусдад төлөх төлбөргүй гэж үзлээ” гэж шийдвэрлэж байгааг хууль зүйн үндэслэлгүй, буруу практик гэж үзэхээр байна.

Бусдад төлөх төлбөргүй гэж үзэх нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан шүүхээс оногдуулсан эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх олон боломжийг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд олгодог. Тухайлбал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх³³33, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох³⁴34 зэргийг хэрэглэх үндэслэл болдог.

³² Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 8 дугаар сарын 9-ний 786 дугаар шийтгэх тогтоол

³³ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйл

³⁴ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.12 дугаар зүйл

Түүнчлэн ХХГХ-ийн улмаас охин биеэ алдсан, бэлгийн замын халдварт өвчинтэй болсон зэрэг хохирол, хор уршиг хохирогчийн эрүүл мэндэд учирсан байхад эдгээрийг эрүүл мэндийн гэмтэлд тооцох эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Өөрийнх нь хүсэл зоригоос шалтгаалахгүйгээр буюу ХХГХ-ийн улмаас насанд хүрээгүй охин анх удаа бусадтай бэлгийн харьцаанд орж онгон хальс нь хөндөгддөг. Энэ нь хэдийгээр хурьцал үйлдсэн эмэгтэй хүний жам ёсны зүйл мэт боловч эмзэг байдлынхаа улмаас насанд хүрээгүй байхдаа ХХГХ-ийн хохирогч болсон охидын бие махбодод хууль бусаар учирсан хор уршиг мөн юм.

Шүүх шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн 2019 оны 8 дугаар сарын 16- ны өдрийн 9712 дугаартай шинжээчийн дүгнэлт: “ О.Н-ийн биед гэмтэл тогтоогдоогүй. О.Н нь бэлгийн харьцаанд орж байсан охин хальс 3.7-н цагийн чиглэлд хуучин урагдалттай байна. О.Н нь тэмбүү өвчний идэвхтэй, хурц хэлбэрийн бэлгийн замын халдварт өвчтэй байна.³⁵



Жишээ – 15

³⁵Мөн хүний эрүүл мэндэд байнгын үлдэцтэй тэмбүү өвчинтэй болсон, цаашилбал эдгэрэх боломжгүй ДОХ гэх мэт өвчний эрсдэл ч ХХГХ-ийн хохирогчийн эрүүл мэндэд бий болсон байх бөгөөд эдгээр хор уршигийг “ноцтой хор уршиг” гэж үзнэ. Тухайлбал, тэмбүү өвчнийг эмчлүүлсэн ч хүний биед насан туршид нь илэрч байдаг төдийгүй тэмбүү өвчтэй хүүхэд төрөх эрсдэлтэй, ДОХ өвчнийг өнөөдрийг хүртэл эдгээх эмчилгээ бий болоогүй.

ХХГХ-ийн хохирогч нарын 80 хувь нь өмгөөлөгчтэй байгаа нь бусад төрлийн гэмт хэргийн хохирогчдоос илүү эрх зүйн хамгаалалттай болжээ гэж дүгнэгдэхээр байна. Гэхдээ ХХГХ-ийн өмгөөлөгчийг чадавхжуулах, мэргэшүүлэх нь хохирогчийн хохирол, хор уршигийг нөхөн сэргээхэд, арилгахад ач холбогдолтой.

³⁵ Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 1020 дугаар шийтгэх тогтоол.

Хохирогч Т.А-ын өмгөөлөгч Д.б-ийн шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтээс: "...хохирогч Ө-г ингээд ярьчих гэж шүүгдэгч нь хохирогчтой тохирч байсан асуудал гарсан. Тухайн үед Ө, А нар насанд хүрээгүй учраас ээж нар нь ирсэн байсан. Ээж нар нь байхад А, Ө хоёр худлаа яриад, өмгөөлөгч миний бие болон шүүх бүрэлдэхүүн асуулт асуухаар хариулахгүй эсвэл хариулж чадахгүй байдалтай болтол нөлөөлсөн байсан. Шүүгдэгчийн өмгөөлөгч Б.М нь "хажуудаа байгаа өмгөөлөгчийг таних уу?" гэж асуухад "танихгүй" гэж хүртэл хэлж байсан. Хохирогч Ө мэдүүлгээсээ буцсан ч гэсэн бусад хохирогч нарын мэдүүлгээр нотлогдож байгаа, шинжлэн судалсан нотлох баримтуудын хүрээнд энэ хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжтой. Ө-ийн хувьд өмгөөлөгчийн зүгээс эхнээс нь энэ хэрэгт оролцож байсан хүний хувьд, хохирогчийг би "Стокхолмын синдром" буюу дасан зохицох эмгэгтэй юм байна гэж харж байна. Энэ эмгэгтэй хохирогч нар өөрийн хохироосон хүнтэй харилцаа тогтоож, тэдгээр хүмүүсийг буцаагаад өмөөрөх сэтгэл зүйтэй байдаг. Өмгөөлөгчийн хувьд, хохирогчийг би энэ талаас нь зөвтгөж харж байгаа.³⁶



Жишээ - 16

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу өмгөөлөгч нь хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог³⁷.

Хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирол, хохирлоос үүдсэн хор уршгийг арилгах талаар идэвхтэй ажиллагааг хийхгүйгээр зөвхөн хохирогчоос мэдүүлэг авах ажиллагаанд оролцох, шүүх хуралдаанд оролцох байдлаар өмгөөлөгч хууль зүйн туслалцаагаа үзүүлэх, мөн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон Хүүхэд, гэр бүл хөгжлийн газрын мэргэжилтнүүд ажлаа даатгах зэрэг байдалтай байна. Зүй нь, хохирогчийн эрүүл мэндэд гарсан өвчлөл, гэмтлийг тогтоох, хохирогчийг худалдаалж олсон орлогыг тогтоох ажиллагааг хийлгэх тодорхой хүсэлтүүдийг гаргах, хэрэгт бэхжүүлэгдсэн хохирогч, гэрч, хэргийн газрын үзлэг, шинжээчийн дүгнэлт зэргүүдтэй бүрэн танилцаж зохих хүсэлтүүдийг гаргаж мөрдөн шалгах ажиллагааг хохирогчид ээлтэйгээр явуулахад дэмжлэг үзүүлэх, хохирол хор уршигтаа холбоотой нотлох баримтуудаа шүүх хуралдаан дээр хэлэлцүүлэн хохирлын нэхэмжлэлээ хангуулах, хохирлыг арилгуулах шийдвэр гаргуулах үүрэгтэй юм.

ХХГХ-ийн улмаас хохирогч жирэмсэлж үр хөндөлт хийлгэсэн үйл явдлын талаар мэдүүлсэн /шигтгээ 5/ байхад жирэмслэлтийг хүчээр

³⁶ Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2023 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн 786 дугаар шийтгэх тогтоол.

³⁷ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Тавдугаар бүлэг.

тасалж байгаа нь хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирол, хор уршиг мөн эсэх, сэтгэцийн эмгэг үүссэн эсэх, дарамтад байснаас хохирогчид гэмтлийн ул мөр, сэтгэцийн эмгэгийн үлдэц байх эсэхийг тогтоолгох ажиллагааг хийлгэх байсан байхад энэ талаар тодорхой хүсэлтийг өмгөөлөгч гаргаагүй, мөрдөн шалгах ажиллагааг хэрэгт явуулаагүй байна.

С.Б, А.Н, А.Г нарын өмгөөлөгч М.Ө-ийн шүүх хуралдаанд гаргасан дүгнэлт:

Хохирогч нарыг жирэмсэн, улмаар үр хөндөлт хийлгэчихсэн, сарын тэмдэг нь ирчихсэн байсан үед ч гэсэн биеийг нь үнэлүүлдэг байснаар охидыг дарамталж байсан гэдэг нь илэрхийлэгдэнэ. Миний үйлчлүүлэгч нарын хохирлоо цаашид Иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэх эрхийг нь нээлттэй үлдээж өгнө үү



Жишээ – 17

ХХГХ-ийн улмаас хохирогч жирэмсэлж үр хөндөлт хийлгэсэн үйл явдлын талаар мэдүүлсэн /жишээ-17/ байхад жирэмслэлтийг хүчээр тасалж байгаа нь хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирол, хор уршиг мөн эсэх, сэтгэцийн эмгэг үүссэн эсэх, дарамтад байснаас хохирогчид гэмтлийн ул мөр, сэтгэцийн эмгэгийн үлдэц байх эсэхийг тогтоолгох ажиллагааг хийлгэх байсан байхад энэ талаар тодорхой хүсэлтийг өмгөөлөгч гаргаагүй, мөрдөн шалгах ажиллагааг хэрэгт явуулаагүй байна.

2.1.4. ХХГХ үйлдэж олсон орлогын тухай

ХХГХ үйлдэж олсон орлогыг тогтоох зорилгоор шүүгдэгчийн банкны данс, хохирогчийн заасан банкны дансанд үзлэг хийж байгаа хэдий ч энэ нь хангалтгүй бөгөөд ХХГХ үйлдэж олсон орлогыг тогтоох ажиллагааны хүрээг өргөжүүлэх, ХХГХ-ийн улмаас олсон орлогыг бодитоор тогтоож, хураах нь энэ төрлийн гэмт хэргийг гарахаас урьдчилан сэргийлэх, хохирол-хор уршгийг арилгахад ач холбогдолтой.

ХХГХ үйлдэж олсон орлогыг нарийвчлан тогтоох, хөрөнгө битүүмжлэх, хохирогчийг хэдэн төгрөгөөр биеийг нь үнэлүүлж байсныг тогтоох зэрэг нь Эрүүгийн хуульд заасан хохирогчийн хохирол, хор уршгийг арилгах³⁸ зорилгоор хийгддэг ажиллагаа юм.

³⁸ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

Насанд хүрээгүй хохирогч Б.М:-10 орчим хоног биеийг маань үнэлсэн. Нэг удаа 60,000, цагаар 100,000 төгрөг, хоногоор 300,000 төгрөгөөр үнэлж байсан. Өдөрт багадаа 100,000 төгрөгөөс 300,000 төгрөг олж байсан. Бүх мөнгийг Ц.У, Ч.Б нар авсан. Маш их гомдолтой байна. Зодуулж, дарамталж хүчээр биеийг үнэлүүлдэг байсан. Маш их гомдолтой байна.



Жишээ – 18

Мөн ХХГХ үйлдэж олсон орлого, түүнийг хэрхэн бусад шилжүүлдэг байсан талаар зарим хохирогчид дараах мэдүүлгүүдийг өгсөн байна. Үүнд:

- Хохирогч Б.З: “Гэртээ бүрэн тавилга авч тохижуулсан. Эдгээр тавилгуудаа зарж өмгөөлөгчийн төлбөрөө төлсөн”;
- Хохирогч О.Н, Б.З нар: “Бид нар үйлчлүүлэгчээсээ төлбөрөө аваад 54..09118 данс руу хийдэг байсан. Энэ нь Э.У эгчийн охины данс.”³⁹;
- Насанд хүрээгүй хохирогч У.С нь: “...дансанд шилжүүлдэг байсан. Гүйлгээний утга нь “Со...-с Бат...-т” гэж хийдэг байсан...”⁴⁰ гэж гэмт хэргийн улмаас олсон орлого хэн рүү, хаашаа ордгийг, юунд зарцуулагддаг талаар мэдүүлжээ. Эндээс, дан ганц шүүгдэгчийн дансны гүйлгээгээр олсон орлогыг нь тогтоох боломжгүй болох нь харагдаж байна.

Түүнчлэн, дээрх жишээнд дурдсан хохирогч нарын мэдүүлэгт дурдсан дугаар дансанд үзлэг хийхэд, гэмт хэрэг үйлдэгдсэн 2019 оны 6-р сарын 01-ний өдрөөс 2020 оны 1-р сарын 29-ний хугацаанд буюу хагас жил гаруй хугацаанд 52,501,956 төгрөгийн орлого орсон байжээ. Уг орлогоос, шүүх тухайн утгатайгаар шилжүүлэгдсэн 7,026,800 төгрөгийг л гэмт хэрэг үйлдэж олсон орлого гэж үзэж улсын орлого болгохоор шийдвэрлэжээ. Хэрэв мөрдөн байцаалтад шүүгдэгч өөр орлого олох боломжгүй байсныг шалгаж тогтоосон байсан бол бүхэлд нь улсын орлого болгох, эсхүл хохирогчийн хохирлыг барагдуулах боломжтой байсан гэж үзэж байна.

³⁸ Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 1453 дугаар шийтгэх тогтоолтой 1902009090033 дугаартай эрүүгийн хэрэг

⁴⁰ Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 317 дугаар шийтгэх тогтоолтой хэрэг

Мөн дээр дурдсан мэдүүлгүүд болох хохирогч О.Н, Б.З нар мөрдөн байцаалтад "...Бид нар үйлчлүүлэгчээсээ төлбөрөө 54..09118 данс руу хийдэг байсан. Энэ нь Э.У эгчийн охины данс. ..." ⁴¹ гэх мэдүүлэг, хохирогч Б.З нь "Гэртээ бүрэн тавилга авч тохижуулсан. Эдгээр тавилгуудаа зарж өмгөөлөгчийн төлбөрөө төлсөн. " гэх мэдүүлгүүдийн дагуу ямар нэг ажиллагаа хийгдээгүй байна.

Дээрх, хэргүүдээс үзэхэд ХХГХ-ийн шүүгдэгчийн хамаарал бүхий этгээд нэг бүрийн дансыг, хохирогчийн мэдүүлгийн "тавилга авсан, хувцас авсан, хоолонд зарцуулсан" гэсэн мэдүүлгийн дагуу мөрдөн шалгах зохих ажиллагаануудыг бүрэн хийх шаардлагатай болох илэрхий байна.

Мөн орлогыг тогтоож боломжгүй гэх үндэслэлээр энэ төрлийн ажиллагааг орхигдуулж болохгүй бөгөөд тухайн гэмт хэрэг давтан үйлдэгдсэн сар, өдрийг нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тооцож, ХХГХ үйлдэж олсон орлогын хэмжээг тогтоох боломжтой гэж харж байна.

Гэмт хэрэг үйлдэгчийн гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хураах ач холбогдолтой төдийгүй, гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг өөрт нь үлдээх нь Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчимд нийцэхгүй.

Хууль тогтоогч гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хэрхэх талаар Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна." гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлнэ." гэж хохирлыг нөхөн төлүүлэхэд зарцуулахаар заасан байхад шууд улсын төсөвт /орлогод/ оруулж байгаа практиктай байна.

Иймээс ХХГХ үйлдэж олсон орлогыг төвлөрүүлэх тусгай санг бий болгож, санд цугларсан хөрөнгийг ХХГХ-ийн хохирогчийн хохирол, хор уршгийг барагдуулахад зарцуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн хэм хэмжээг боловсруулж болохоор байна.

Судалсан 17 ХХГХ-ийг үйлдэхдээ ашигласан 7 тээврийн хэрэгслийг битүүмжилсэн ба нийт 48,458,000 төгрөгөөр үнэлэгдэж, шүүх 48,458,000

⁴¹ Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 1453 дугаар шийтгэх тогтоолтой 1902009090033 дугаартай эрүүгийн хэрэг

төгрөгийг улсын орлого болгохоор шийдвэрлэжээ. Гэтэл хуульд гэмт хэргийн хохирлыг нөхөн төлөхөд зарцуулна гэж заасан.

Хохирлыг нөхөн төлөхөд зарцуулах ёстой мөнгийг улсын орлого болгох нь эрх зүйн хувьд ч үр дагавартай. Мөнгийг шүүгдэгч улсын орлогод оруулсныг хохирол төлсөн гэж үзэх үндэслэлгүй. Харин хохирогчид олгохоор шийдвэрлэснийг хохирогчид төлсөн бол хохирлыг төлсөн гэж үзэх үндэслэл болно.

ДҮГНЭЛТ

Судлаачийн зүгээс энэхүү судалгааг гүйцэтгэхэд ашигласан нийт 17 ХХГХ-ийн 49 хохирогчийн хэргийн материал, холбогдох шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолд дүн шинжилгээ хийж, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид учирсан хохирлыг практикт хэрхэн тогтоож байгаа, тэдэнд учирсан нийтлэг хор уршиг, бие махбод болон сэтгэцэд бий болсон өөрчлөлт, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, бий болсон эд хөрөнгөөр хохирогчийн хохирлыг барагдуулж байгаа эсэх талаар асуудлыг тодрууллаа. Энэхүү хүрээнд ХХГХ-ийн хохирогчийн хохирол, хор уршгийг шийдвэрлэж буй шүүхийн практиктай холбоотой дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуульд “Хүний эрүүл мэндэд учирсан хохирол”-ыг гэмт хэргийн шинж болгож заасан, түүнчлэн эрүүл мэндийн хохиролтой уялдуулан сэтгэцэд учирсан хохирлын нөхөн төлбөр гаргуулах болсон тул Эрүүл мэндийн тухай хуульд тодорхойлсон “эрүүл мэнд”-ийг бүрэн хамруулж ойлгох байдлаар Эрүүгийн хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах нь зүйтэй байна. Өнөөгийн практикт зөвхөн Шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоох журмыг үндэслэн гаргасан хохирогчийн биед учирсан гэмтлийн зэргээр хохирогчийн эрүүл мэндэд учирсан хохирлыг тогтоож байгаа нь хэт хязгаарлагдмал байна.
2. ХХГХ-ийн улмаас хохирогч эмэгтэйчүүд хүүхэдтэй болох, улмаар төрүүлэн өсгөн хүмүүжүүлж буй тохиолдолд ХХГХ үйлдсэн этгээдээс сар бүр хүүхдийн тэтгэлэгтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөр гаргуулах эрх зүйн зохицуулалтыг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлтээр тусгаж өгөх шаардлагатай байна. Эсхүл Иргэний хуульд холбогдох өөрчлөлтийг оруулах нь зүйтэй байна.
3. ХХГХ нь Олон Улсын өмнө хүлээсэн үүрэг бүхий конвенцитай, нийгмийн аюул хэр хэмжээ ихтэй гэмт хэрэг болохынх нь хувьд

энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж олсон орлого, үйлдэхдээ ашигласан эд зүйлсийг хураан авч төвлөрүүлдэг тусгай сантай болох шаардлагатай байна. Энэхүү санд төвлөрсөн хөрөнгө, орлогыг эргээд ХХГХ-ийг илрүүлэх, хохирогчийн хамгаалалт, хохирол, хор уршгийг тогтоох, арилгахад зарцуулдаг байх хамгийн оновчтой хувилбар гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ

Судлаачийн зүгээс судалгааны дүгнэлтэд үндэслэн ХХГХ-ийн хохирогчийн хохирол, хор уршгийг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхийн шийдвэрийг илүү төгөлдөржүүлэх зорилгоор дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Хохирогчид учирсан гэм хорын хохирлыг тогтоох зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу ХХГХ-ээс шууд шалтгаантайгаар эрүүл мэнд нь өвчилсөн, эмгэгтэй болсон, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байдал нь муудсан байдлыг тогтоох ажиллагааг мөрдөн шалгах ажиллагаанд хийх, үүнтэй холбоотой эрх зүйн орчин буюу Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах.
2. ХХГХ-ийн улмаас хохирогч эмэгтэйн төрүүлсэн хүүхдэд ХХГХ гэмт хэрэг үйлдсэн этгээдээс сар бүр хүүхдийн тэтгэлэгтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг гаргуулах нэхэмжлэлийг гаргаж шүүхээр шийдвэрлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.
3. ХХГХ-ийн улмаас хохирогч эдгэршгүй өвчин, эмгэгтэй /хор уршиг/ болсон бол энэ талаар тусгай мэдлэг бүхий шинжээчийн дүгнэлтийг гаргуулж, гэм хорын хохирлын нэхэмжлэх бүхий л ажиллагааг мөрдөгч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нар хийх.
4. Шүүх хохирогчийн хохирол, хор уршгийн талаар нэхэмжлэлээ иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэй гэж шийдвэрлэж байгаа тохиолдолд “шүүгдэгчийг бусдад төлөх төлбөргүй” гэж шийтгэх тогтоолдоо дүгнэхгүй байх. Энэ нь Эрүүгийн хуулийн “эрүүгийн хариуцлага нь тухайн хүний үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.” гэсэн шударга ёсны зарчимд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “...хүний эрх, хууль

ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино” гэсэн зорилгод нь нийцнэ.

5. ХХГХ-ийн хохирогчийн хохирол, хор уршгийг бүрэн тогтоох, арилгахад онцгой ач холбогдолтой тул сайн дурынх нь үндсэн дээр ХХГХ-ийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлдэг мөргөшсэн өмгөөлөгч нарыг бэлтгэх.
6. ХХГХ-ийн хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогддог / Гэр бүл, хүүхэд хөгжлийн газрын мэргэжилтнүүд/ субъектүүдийн хохирогчид үзүүлэх дэмжлэг, туслалцаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох мэдлэгийг сайжруулж, чадавхжуулах.
7. ХХГХ үйлдэж олсон орлогыг хаашаа хэрхэн орж байсан зарцуулагдаж байсан зэргийг тогтох ажиллагааг хийж, гэмт хэрэг үйлдэж олсон орлого, хөрөнгийг бүрэн хураахуйц ажиллагааг мөрдөн байцаалтад бүрэн хийх.
8. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1,3 дахь хэсэгт зааснаар хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэж байх.

Хүйсийн тэгш эрх төв ТББ

Хаяг:

Монгол Улс,

Улаанбаатар хот 211238

Шуудангийн хайрцаг-321,

Утас/факс: 976-11-311512

Итгэлийн утас: 1800-1903

Нүүр хуудас: Mongolia Gender Equality Center

И-мэйл: gendereqcen@gmail.com info@stoptrafficking.mn

Вэб хуудас: www.stoptrafficking.mn